



ГАРЧИГ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|------|--|------|
| 241. | Протокол соёрхон батлах тухай | 1038 |
| 242. | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай | 1040 |
| 243. | Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 1070 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|-----------|------|
| 244. | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгууль товлон зарлах тухай | Дугаар 29 | 1071 |
|------|--|-----------|------|

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|-----------|------|
| 245. | Эрчим хүчний зохицуулах хорооны дүрэм батлах тухай | Дугаар 49 | 1072 |
| 246. | Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн нэмэгдлийн хэмжээ тогтоох тухай | Дугаар 50 | 1076 |
| 247. | Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөлгөөний зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай | Дугаар 51 | 1077 |
| 248. | Байнгын төлөөлөгчийг томилох, эгүүлэн татах тухай | Дугаар 52 | 1081 |

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|-----------|------|
| 249. | Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай | Дугаар 03 | 1081 |
|------|--|-----------|------|



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 04 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

ПРОТОКОЛ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зүүн өмнөд Азийн Найрамдал, хамтын ажиллагааны гэрээнд өөрчлөлт оруулах тухай Гуравдугаар протоколыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д. ДЭМБЭРЭЛ

ЗҮҮН ӨМНӨД АЗИЙН НАЙРАМДАЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ГУРАВДУГААР ПРОТОКОЛ

Бруней Даруссалам
Камбожийн Вант Улс
Бүгд Найрамдах Индонез Улс
Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс
Малайз Улс
Мьянмарын Холбооны Улс
Бүгд Найрамдах Филиппин Улс
Бүгд Найрамдах Сингапур Улс
Тайландын Вант Улс
Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс
Австралийн Холбооны Улс
Бүгд Найрамдах Бангладеш Улс
Бүгд Найрамдах Хятад Ард Улс
Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс
Бүгд Найрамдах Франц Улс
Бүгд Найрамдах Энэтхэг Улс
Япон Улс
Монгол Улс
Шинэ Зеланд Улс
Лалын Бүгд Найрамдах Пакистан Улс
Папуа Шинэ Гвиней
Бүгд Найрамдах Солонгос Улс
Оросын Холбооны Улс
Бүгд Найрамдах Ардчилсан Шри Ланка Ард Улс
Бүгд Найрамдах Ардчилсан Тимор-Лесте Улс
Бүгд Найрамдах Турк Улс
Америкийн Нэгдсэн Улс
Цаашид “Хэлэлцэн тохирогч талууд” гэх:



Зүүн өмнөд Азийн болон бусад энхийг эрхэмлэгч бүх улс, тэр дундаа Зүүн өмнөд Азийн бүс нутагтай хөрш зэргэлдээ орших улсууд болон гишүүд нь зөвхөн тусгаар улсуудаас бүрдсэн бүс нутгийн байгууллагатай хамтын ажиллагаа хөгжүүлэхийг эрмэлзэн,

1976 оны 2 дугаар сарын 24-ний өдөр Бали мужийн Дэнпасар хотноо байгуулсан Зүүн өмнөд Азийн Найрамдал, хамтын ажиллагааны гэрээний /цаашид “Найрамдлын гэрээ” гэж/ удиртгал хэсгийн 5-д дэлхийн энх тайван, аюулгүй байдал болон эв найрамдалыг бэхжүүлэхэд энхийг эрхэмлэгч Зүүн өмнөд Азийн болон бусад бүх улсуудтай хамтран ажиллах нь чухал гэж заасныг харгалзан,

ДАРААХЬ ЗҮЙЛИЙГ ХЭЛЭЛЦЭН ТОХИРОВ: 1 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Найрамдлын гэрээний 18 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг дараахь байдлаар өөрчилж байна:

“Энэхүү гэрээ нь Зүүн өмнөд Азийн бус улсууд болон гишүүд нь зөвхөн тусгаар улсуудаас бүрдсэн бүс нутгийн байгууллагууд нэгдэн ороход нээлттэй байна. Гэхдээ ийм улс болон бүс нутгийн байгууллага гэрээнд нэгдэн орохыг Зүүн өмнөд Азийн бүх улс, нэрэлбэл, Бруней Даруссалам, Камбожийн Вант Улс, Бүгд Найрамдах Индонез Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Малайз Улс, Мьянмарын Холбооны Улс, Бүгд Найрамдах Филиппин Улс, Бүгд Найрамдах Сингапур Улс, Тайландын Вант Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс зөвшөөрсөн байх ёстой.”

2 ДУГААР ЗҮЙЛ

Найрамдлын гэрээний 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг дараахь байдлаар өөрчилж байна:

“Гэхдээ энэ зүйл Зүүн өмнөд Азийн бус Хэлэлцэн тохирогч аливаа тал бүс нутгийн маргаан шийдвэрлэх тогтолцооны хүрээнд шийдвэрлэгдэх маргаанд шууд оролцож буй тохиолдолд л зөвхөн тухайн талд үйлчилнэ.

3 ДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Протоколыг соёрхон батлах бөгөөд соёрхон баталсан тухай Хэлэлцэн тохирогч талуудын сүүлчийн Батламж жуух бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Энэхүү Протоколыг 2010 оны 7 дугаар сарын 23-ны өдөр Вьетнам Улсын Ханой хотноо англи хэлээр нэг эх хувь үйлдэв.

**ХЭЛЭЛЦЭН ТОХИРОГЧ ТАЛУУДЫГ ТӨЛӨӨЛЖ
ГАРЫН ҮСЭГ**



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 04 дүгээр
сарын 27-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үндсэн зарчим, журмыг тодорхойлж, уг сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомж

2.1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай², Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль³, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“сонгогч” гэж Улсын нийслэлд байнга оршин суугч буюу Иргэний бүртгэлийн тухай хуулийн⁴ 25.1-д заасны дагуу оршин сууж байгаа засаг захиргааны нэгждээ 180 хоногоос дээш хугацаагаар оршин сууж байгаа бөгөөд ийнхүү оршин суух бүртгэлтэй Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн, түүнчлэн энэ хуулийн 6.3, 6.4-т заасан иргэнийг;

3.1.2.“сонгуулийн эрх бүхий иргэн” гэж Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 3.1.2-т заасан иргэнийг;

¹Монгол Улсын Үндсэн хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

²Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2007 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

³Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 48 дугаарт нийтлэгдсэн.

⁴Иргэний бүртгэлийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1999 оны 49 дугаарт нийтлэгдсэн.



3.1.3.“нэр дэвшигч” гэж энэ хуульд заасан журмын дагуу Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшиж бүртгүүлэн нэр дэвшигчийн үнэмлэх авсан иргэнийг.

4 дүгээр зүйл.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль

4.1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль нь Улсын нийслэл /цаашид “нийслэл” гэх/-д байнга оршин сууж байгаа Монгол Улсын иргэд нутгийн өөрөө удирдах байгууллагаа өөрсдийн төлөөлөгчдөөр бүрдүүлэх үндсэн арга мөн.

4.2.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль /цаашид “сонгууль” гэх/ нь ээлжит, ээлжит бус, нөхөн, дахин сонгууль гэсэн төрөл зүйлтэй байна.

4.3.“Ээлжит сонгууль” гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар дөрвөн жил тутам явагдаж байгаа сонгуулийг хэлнэ.

4.4.Ээлжит сонгуулийг энэ хуулийн 4.3-т заасан хугацаанд заавал явуулах бөгөөд энэ хуулийн 8.3-т заасан онцгой нөхцөлөөс бусад тохиолдолд энэ хуулийн 4.3-т заасан хугацааг өөрчлөхийг хориглоно.

4.5.“Ээлжит бус сонгууль” гэж Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15.1-д заасны дагуу Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсон тохиолдолд явагдах сонгуулийг хэлнэ.

4.6.“Нөхөн сонгууль” гэж энэ хуулийн 49.1, 49.2-т зааснаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн орон гарсан суудлыг нөхөх зорилгоор явагдах сонгуулийг хэлнэ.

4.7.“Дахин сонгууль” гэж ээлжит, ээлжит бус сонгуулийг бүхэлд нь хүчингүйд тооцсоны дараа шинээр нийслэлийн нийт нутаг дэвсгэрт, эсхүл ээлжит, ээлжит бус болон нөхөн сонгуулийг нэг буюу хэд хэдэн сонгуулийн тойрогт хүчингүйд тооцсоны дараа тухайн тойрогт явагдах сонгуулийг хэлнэ.

4.8.Сонгуулиар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10.1.2-т заасны дагуу Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 45 төлөөлөгчийг сонгоно.

4.9.Энэ хуулийн 25.1-д заасан 30-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 12.1-д заасан сонгуулийн тойргоос, энэ хуулийн 25.2-т



заасан 15-аас илүүгүй нэр дэвшигчийг улс төрийн нам буюу улс төрийн намуудын сонгуулийн эвсэл /цаашид “нам, эвсэл” гэх/-ийн жагсаалтаас тус тус сонгоно.

5 дугаар зүйл. Сонгуулийн үндсэн зарчим

5.1. Сонгуулийн тогтолцоо нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг нийслэлд байнга оршин суух бүртгэлтэй Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгох эрхийг хангахад үндэслэх бөгөөд сонгуульд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 5.3-5.7-д заасан зарчмыг баримтална.

6 дугаар зүйл. Нийслэлийн оршин суугчийн сонгох, сонгогдох эрх

6.1. Нийслэлд байнга оршин суух бүртгэлтэй болон энэ хуулийн 6.3, 6.4-т заасан Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн /цаашид “иргэн” гэх/ үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр сонгуульд оролцох эрхтэй.

6.2. Энэ хуульд заасан шаардлагыг хангасан арван найман нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай иргэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдох эрхтэй.

6.3. Байнга оршин сууж байгаа газраасаа нийслэлд шилжин суралцаж байгаа оюутан, түүнчлэн нийслэлд байршилтай цэргийн анги, нэгтгэлийн цэргийн алба хаагч түр оршин суугаа газрынхаа сонгуулийн хэсэгт сонгуульд оролцож санал өгч болно.

6.4. Улсын Их Хурлын сонгуульд нийслэлд санал өгөх эрх бүхий Монгол Улсын иргэн сонгуульд санал өгөх эрхтэй.

6.5. Иргэний сонгох, сонгогдох эрхийг хууль бусаар хязгаарлахыг хориглох бөгөөд энэ заалтыг зөрчсөн этгээдэд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6.9, 6.10-т заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

6.6. Эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, эсхүл хорих газар ял эдэлж байгаа иргэн сонгуульд оролцох эрх эдлэхгүй бөгөөд үүнийг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6.5, 6.6-д зааснаар ойлгоно.



7 дугаар зүйл.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид нэр дэвшүүлэх эрх

7.1.Нийслэлд өөрийн салбартай, сонгууль зарлахаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгэгдсэн нам, эвсэл сонгуульд оролцож, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /цаашид “Хурал” гэх/-ын төлөөлөгчид нэр дэвшүүлэх эрхтэй.

7.2.Энэ хуулийн 6.2-т заасан иргэн Хурлын төлөөлөгчид нэрээ бие даан дэвшүүлэх эрхтэй.

8 дугаар зүйл.Сонгууль товлон зарлах

8.1.Сонгуулийг санал авах өдрөөс 50-иас доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурал товлон зарлана.

8.2.Ээлжит сонгуулийн санал авах өдөр нь Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдөр байна.

8.3.Сонгуулийг хойшлуулах, сонгуулийн үйл ажиллагааг зогсоохтой холбогдсон харилцааг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 8.5, 8.6-д зааснаар зохицуулна.

8.4.Хурал өөрөө тарах шийдвэр гаргасан бол ийнхүү тарснаас хойш сонгуулийг 30 хоногийн дотор Улсын Их Хурал товлон зарлана.

9 дүгээр зүйл.Сонгуулийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

9.1.Сонгуулийн үйл ажиллагаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан зарчмыг баримтална.

10 дугаар зүйл.Сонгуулийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгаа

10.1.Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дор дурдсан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:

10.1.1.сонгуулийн тухай хууль тогтоомж, түүнийг сурталчилсан материал хэвлэх, тамга, тэмдэг, лац, тусгай тэмдэг тавих хэрэгсэл, саналын хайрцаг хийх болон тэдгээрийг тээвэрлэх, хүргэх зардал;



10.1.2.сонгууль зохион байгуулахтай холбогдуулан сонгуулийн хууль тогтоомжид нийцүүлэн Сонгуулийн ерөнхий хорооноос нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан дүрэм, журам, заавар, гарын авлагыг хэвлэх, тэдгээрийг хүргэх зардал;

10.1.3.нийслэлийн сонгуулийн хороо, нийслэлийн сонгуулийн тойргийн хороо болон хэсгийн хороо /цаашид “сонгуулийн хороод” гэж/-ны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалтын зардал;

10.1.4.онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал;

10.1.5.нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний зарцуулалтыг хянахад гарах зардал;

10.1.6.сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдон гарах бусад зардал.

10.2.Хурал нь сонгуулийн ажилд шаардагдах дор дурдсан зардлыг сонгуулийн жилийн нийслэлийн төсөвт тусган санхүүжүүлнэ:

10.2.1.нэр дэвшигч, нам, эвслийн сонгуулийн ажил эрхэлсэн ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагч, түүнчлэн сонгуулийн хорооны гишүүний болон ажиглагчийн үнэмлэх, саналын хуудас, бие даан нэр дэвшигчийг дэмжигч-сонгогчдын гарын үсэг зуруулах маягт, сонгогчдын нэрийн жагсаалт, сонгуулийн дүн мэдээний маягт, сонгуулийн хорооны албан бичгийн хэвлэмэл хуудас хэвлэх, тээвэрлэх, хүргэх зардал;

10.2.2.сонгуулийн хорооны ажиллах болон санал авах байрыг тохижуулах зардал;

10.2.3.сонгуулийн тухай хууль тогтоомж, түүнчлэн Хурал болон сонгуулийн холбогдох хорооноос сонгууль зохион байгуулахтай холбогдуулан гаргасан шийдвэр, заавар, гарын авлагыг хэвлэх, тэдгээрийг сонгогчдод хүргэх, сурталчлах, тайлбарлан таниулах, сонгогчдыг бусад мэдээллээр хангах арга хэмжээний зардал;

10.2.4.дахин санал хураах, ээлжит бус, нөхөн болон дахин сонгууль явуулах зардал;

10.2.5.сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүний тухайн сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал;



10.2.6.сонгуулийн хороодын бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, албан томилолтын зардал;

10.2.7.Хурлаас тогтоосон бусад зардал.

10.3.Энэ хуулийн 10.2-т заасан зардлын хэмжээг Хурлын Тэргүүлэгчид санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө тогтооно.

10.4.Нийслэлийн сонгуулийн хороо энэ хуулийн 10.2.1-д заасан үнэмлэх, маягт, албан бичгийн хэвлэмэл хуудасны загварыг батлах ба хууль тогтоомж, дүрэм, журам, гарын авлага, материал, тамга, тэмдэг, лац, бусад шаардлагатай хэрэгслийг холбогдох сонгуулийн хороодод хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

10.5.Хурал нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулагдсан сонгуулийн тойргуудын мэдээллийн нэгтгэсэн дүн, түүнчлэн энэ хуулийн 10.1-д заасны дагуу улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын тооцоог гаргаж Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

10.6.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 10.5-д заасан мэдээлэл, тооцоог нэгтгэж улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын талаарх санал боловсруулж Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурал уг саналыг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, шийдвэрлэнэ.

10.7.Сонгуулийн хорооны ажиллах, санал авах байрыг төрийн болон орон нутгийн өмчит буюу тэдгээр өмчийн оролцоотой хуулийн этгээд үнэ төлбөргүй гаргаж өгнө.

10.8.Сонгуулийн хороог ажлын байр, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах асуудлыг тухайн шатны Засаг дарга хариуцна.

10.9.Энэ хуулийн 10.1, 10.2-т заасан зардлын гүйцэтгэлд төрийн аудитын төв болон орон нутгийн байгууллага аудит хийж, дүгнэлт гаргана.

10.10.Энэ хуулийн 10.7-д заасныг зөрчсөн албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 10.8-д заасныг зөрчсөн Засаг даргыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.



**ХОЁРДУГААР БҮЛЭГ
СОНГУУЛИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

11 дүгээр зүйл. Сонгуулийн нутаг дэвсгэрийн хуваарь

11.1. Сонгуулийн нутаг дэвсгэр нь нийслэлийн нутаг дэвсгэр байна.

11.2. Энэ хуулийн 4.9-д заасан Хурлын 30 төлөөлөгчийг сонгох сонгуулийн нутаг дэвсгэр нь сонгуулийн тойрог /цаашид “тойрог” гэх/-т хуваагдана.

11.3. Тойрог нь сонгуулийн хэсэг /цаашид “хэсэг” гэх/-т хуваагдана.

12 дугаар зүйл. Тойрог, хэсэг байгуулах

12.1. Хурал сонгуулийн тойргийг санал авах өдрөөс 50-аас доошгүй хоногийн өмнө байгуулж, мандатыг хуваарилж, тойргийн дугаар, нутаг дэвсгэр, төвийг сонгогчдод мэдээлнэ.

12.2. Дор дурдсан тохиолдолд Хурлын Тэргүүлэгчид энэ хуулийн 12.1-д заасан хугацаанаас өмнө тойрог өөрчлөх саналыг Хуралд оруулна:

12.2.1. засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь өөрчлөгдсөн нь тойргийн зохион байгуулалтад нөлөөлөхөөр байвал;

12.2.2. тойргийн хүн амын тоо нь өмнөх сонгуулиас хойших хугацаанд 20-оос дээш хувиар өөрчлөгдсөн нь тойргийн зохион байгуулалтад нөлөөлөхөөр байвал.

12.3. Хурал нь энэ хуулийн 12.2-т заасан саналыг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор хэлэлцэж шийдвэрлэнэ.

12.4. Энэ хуулийн 11.3-т заасан хэсэг нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 13.1-д заасны дагуу байгуулагдсан сонгуулийн хэсэг байна.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ
СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ, БҮРЭН ЭРХ**

13 дугаар зүйл. Сонгуулийн байгууллага

13.1. Сонгуулийг Нийслэлийн сонгуулийн хороо, нийслэлийн сонгуулийн тойргийн хороо болон сонгуулийн хэсгийн хороод зохион байгуулна.



13.2. Сонгуулийн ерөнхий хороо Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн⁵ 7.5-д заасны дагуу энэ хуулийн 13.1-д заасан сонгуулийн хороодод сонгуулийг зохион байгуулж явуулахад нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлнэ.

13.3. Сонгуулийг зохион байгуулах, санал хураалтын дүнг нэгтгэн гаргах үүрэг бүхий сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр дор дурдсан журмаар байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийн сонгогчдод мэдээлнэ:

13.3.1. Нийслэлийн сонгуулийн хороог санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө Хурлын Тэргүүлэгчид;

13.3.2. нийслэлийн сонгуулийн тойргийн хороо /цаашид “нийслэлийн тойргийн хороо” гэх/-г санал авах өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө Нийслэлийн сонгуулийн хороо.

13.4. Сонгуулийн хэсгийн хороо нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу байгуулагдах хэсгийн хороо байна.

13.5. Энэ хуулийн 13.3-т заасан сонгуулийн хороодын бүрэлдэхүүний тоог хүн амын тоо, ажлын цар хэмжээг харгалзан Хурлын Тэргүүлэгчид тогтооно.

13.6. Энэ хуулийн 13.3-т заасан сонгуулийн хороо бүрэн эрхээ түүнийг байгуулсан этгээд нь дуусгавар болгох хүртэлх хугацаанд хэрэгжүүлнэ.

13.7. Сонгуулийн хороод нь сонгуулийн байгууллагатай холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 14.4-14.6, 14.8-14.15-д заасан журмыг баримтална.

14 дүгээр зүйл. Нийслэлийн сонгуулийн хорооны бүрэн эрх

14.1. Нийслэлийн сонгуулийн хороо нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1. сонгууль зохион байгуулах ажлыг төлөвлөх, түүнийг зохион байгуулах арга хэмжээг авах;

⁵Сонгуулийн төв байгууллагын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2006 оны 5 дугаарт нийтлэгдсэн.



14.1.2.сонгуулийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгаж, нийтээр сахин биелүүлэх нөхцөлийг хангах;

14.1.3.сонгуультай холбогдсон асуудлаар нийслэлийн тойргийн хороо, хэсгийн хороодын үйл ажиллагааг зохион байгуулалт, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;

14.1.4.сонгууль зохион байгуулах асуудлаар тухайн нутаг дэвсгэр дэх төрийн холбогдох байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

14.1.5.сонгуульд оролцохоо илэрхийлсэн нам, эвслийг бүртгэх;

14.1.6.нэр дэвшигчийг бүртгэж, үнэмлэх олгох;

14.1.7.сонгуулийн ажилд зориулан улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, зохих журмын дагуу харьяалах нийслэлийн тойргийн хороо, хэсгийн хороодод хуваарилах, зарцуулалтад хяналт тавих;

14.1.8.сонгууль зохион байгуулах асуудлаар нийслэлийн тойргийн хороо, хэсгийн хороодын болон нийслэлийн нутаг дэвсгэр дэх зохих шатны төрийн байгууллагын удирдах албан тушаалтны мэдээллийг сонсож, шаардлагатай арга хэмжээ авах;

14.1.9.нийслэлийн тойргийн хороо, хэсгийн хороодын шийдвэрийн талаарх өргөдөл, гомдлыг бүрэн эрхийнхээ хүрээнд хянан шийдвэрлэж бичгээр хариу өгөх;

14.1.10.Сонгуулийн ерөнхий хорооноос хууль тогтоомжид заасны дагуу ирүүлсэн техник хэрэгсэл, бусад зүйлийг нийслэлийн тойргийн хороо, хэсгийн хороодод хуваарилах;

14.1.11.холбогдох баримт материалыг хэвлүүлэх, нийслэлийн тойргийн хороо, хэсгийн хороодод хуваарилах;

14.1.12.нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах;

14.1.13.сонгуулийн нэгдсэн дүнг гаргаж, нийтэд мэдээлэх, Хурлын төлөөлөгчдийг бүртгэж, тэдний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх шийдвэрийн төсөл боловсруулж, Хуралд өргөн мэдүүлэх, сонгуулийн дүнг Сонгуулийн ерөнхий хороонд хүргэх;



14.1.14.дахин санал хураах, нөхөн болон дахин сонгууль явуулах ажлыг өөрийн бүрэн эрхийн хүрээнд хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах;

14.1.15.сонгуулийн ажилтай холбогдолтой баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу цэгцэлж Хурлын архивт хүлээлгэн өгөх;

14.1.16.сонгууль зохион байгуулахтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооноос хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэр, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаа, үүргийг биелүүлэх;

14.1.17.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

14.2.Нийслэлийн сонгуулийн хороо нь сонгуультай холбоотой тойргийн хороо, хэсгийн хорооны хууль тогтоомжид нийцээгүй шийдвэрийг хүчингүй болгох эрхтэй.

14.3.Нийслэлийн сонгуулийн хорооны дарга дотоод ажлын асуудлаар захирамж гаргах эрхтэй.

15 дугаар зүйл.Нийслэлийн тойргийн хорооны бүрэн эрх

15.1.Нийслэлийн тойргийн хороо нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд энэ хуулийн 14.1.1-14.1.4, 14.1.7-14.1.9, 14.1.14-т зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1.сонгуульд оролцогч нам, эвслийн сонгуулийн ажил эрхэлсэн ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагчийг бүртгэж, үнэмлэх олгох;

15.1.2.энэ хуулийн 10.1.1, 14.1.10, 14.1.11-д заасан материал, тамга, тэмдэг, лац, үнэмлэх, маягт, саналын хуудас, албан бичгийн хэвлэмэл хуудас зэргийг хэсгийн хороодод хуваарилах;

15.1.3.санал хураалтын дүнгийн тухай харьяалах хэсгийн хороодын шийдвэрийг үндэслэн сонгуулийн дүнг нэгтгэн Нийслэлийн сонгуулийн хороонд хүргэх;

15.1.4.сонгуулийн баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу цэгцэлж Нийслэлийн сонгуулийн хороонд хүлээлгэн өгөх;



15.1.5.сонгуультай холбогдуулан Нийслэлийн сонгуулийн хорооноос хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэр, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаа, үүргийг биелүүлэх;

15.1.6.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

15.2.Нийслэлийн тойргийн хороо нь харьяалах хэсгийн хороодын хууль тогтоомжид нийцээгүй шийдвэрийг хүчингүй болгох эрхтэй.

16 дугаар зүйл.Хэсгийн хорооны бүрэн эрх

16.1.Хэсгийн хороо Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 18.3-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэн, сонгогчдын санал авах, сонгуулийн санал хураалтын дүнг нийслэлийн тойргийн хороонд хүргэх ажлыг зохион байгуулна.

17 дугаар зүйл.Сонгуулийн хороодын ажлын зохион байгуулалт

17.1.Сонгуулийн хороод нь ажлынхаа зохион байгуулалттай холбогдсон харилцаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг баримтална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ

18 дугаар зүйл.Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах

18.1.Сонгуулийг зохион байгуулж явуулахдаа Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу үйлдсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг баримтална.

19 дүгээр зүйл.Сонгогчдын нэрийн жагсаалттай холбогдсон гомдлыг шийдвэрлэх журам

19.1.Сонгогчдын нэрийн жагсаалттай холбогдсон гомдлыг шийдвэрлэхэд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

20 дугаар зүйл.Сонгогч шилжих

20.1.Сонгогч шилжихтэй холбогдсон харилцаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

ТАВДУГААР БҮЛЭГ НАМ, ЭВСЭЛ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ

21 дүгээр зүйл. Нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх

21.1. Энэ хуулийн 7.1-д заасан нам, эвсэл сонгуульд оролцох эрхтэй.

21.2. Нам, эвсэл нь сонгуульд оролцох хүсэлтээ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 23.4, 23.5-д заасан баримт бичгийн хамт Нийслэлийн сонгуулийн хороонд сонгууль товлон зарласан өдрөөс хойш тав хоногийн дотор ирүүлнэ.

22 дугаар зүйл. Намууд эвсэл байгуулах, эвслийн гэрээ

22.1. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол сонгуульд намууд эвсэл байгуулж оролцох, эвслийн гэрээтэй холбогдсон харилцаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан холбогдох журмыг баримтална.

22.2. Эвсэл албан ёсны нэр, бэлэгдэлтэй байх бөгөөд түүнийг хувь хүн, улс, үндэстэн, овгийн нэрээр болон өмнөх сонгуульд өөр намуудын эвслийн хэрэглэсэн нэрээр нэрлэхийг тус тус хориглох ба нэгэнт зарлагдсан эвслийн нэрийг сонгуулийн явцад болон шинээр сонгогдсон Хурлын бүрэн эрхийн хугацаанд өөрчлөхийг хориглоно.

22.3. Эвслийг төлөөлөх байгууллага нь эвсэлд нэгдэн орсон нам бүрээс тухайн намын эрх бүхий төлөөллийн байгууллагаас томилогдсон төлөөлөгчдөөс бүрдэх бөгөөд эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, эвслийн гэрээнд өөрчлөлт оруулах, эвслийн жагсаалтаар нэр дэвшигчдийн дарааллыг тогтоох, Хурлын дарга, нийслэлийн Засаг дарга зэрэг улс төрийн албан тушаалд нэр дэвшүүлэх, нөхөн сонгуульд нэр дэвшүүлэх, эвслийн гэрээг цуцлах зэргээр сонгууль болон эвсэлтэй холбогдсон асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлэх боловч намуудад ногдсон суудлын тоог өөрчлөх эрхгүй.

22.4. Эвслийн гэрээ нь тухайн сонгууль, түүний үр дүнд байгуулагдсан Хурлын бүрэн эрхийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

22.5. Эвсэлд нэгдэн орсон намууд нь Хурлын ээлжит болон нөхөн сонгууль, түүнчлэн шинээр сонгогдсон Хуралд нэг этгээд болж оролцох бөгөөд эвслийн аль нэг нам дангаараа /эвслээс гадуур/ нэр дэвшүүлэх, сонгуулийн зардлын данс нээлгэх, өөр намуудын эвсэлд нэгдэн орох, бие даан болон өөр эвсэл байгуулан сонгуульд оролцохыг хориглох бөгөөд хэрэв аль нэг нам нь ийм шийдвэр гаргасан бол эвслийг тарсан гэж үзнэ.



22.6.Эвсэлд нэгдэн орсон нам хэдийд ч эвслээс гарах эрхтэй бөгөөд намын эрх бүхий төлөөллийн байгууллага нь энэ хуулийн 22.3-т заасан эвслийг төлөөлөх байгууллагад энэ тухай албан ёсоор мэдэгдсэнээр тухайн намыг эвслээс гарсанд тооцох бөгөөд энэ тохиолдолд эвслийг тарсан гэж үзнэ.

22.7.Энэ хуулийн 22.5, 22.6-д заасны дагуу эвсэл нэгэнт тарсан бол Хурлын тухайн сонгуулийн явцад болон түүний үр дүнд байгуулагдсан Хуралд эвслийн бүрэлдэхүүнд орж байсан намууд дахин нэгдэж эвсэл байгуулахыг хориглоно.

22.8.Анхнаасаа эвсэлд нэгдээгүй намууд, түүнчлэн энэ хуулийн 22.5, 22.6-д заасны дагуу эвсэл нэгэнт тарсан бол Хурлын тухайн сонгуулийн явцад дахин нэгдэж эвсэл байгуулахыг хориглоно.

23 дугаар зүйл.Сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх

23.1.Нийслэлийн сонгуулийн хороо энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу сонгуульд оролцохоо илэрхийлсэн нам, эвслийг бүртгэхдээ тэдгээрийн ирүүлсэн баримт бичиг үнэн зөв, гүйцэд эсэхийг нягтлан шалгаж, уг баримт бичгийг хүлээн авснаас хойш тав хоногт багтаан сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх эсэх тухай шийдвэр гаргана.

23.2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25.3-т заасан үндэслэл байвал Нийслэлийн сонгуулийн хороо нам, эвслийг бүртгэхээс татгалзана.

23.3.Нийслэлийн сонгуулийн хороо нам, эвслийг бүртгэсэн тухай шийдвэр гаргасан бол батламж олгоно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИД НЭР ДЭВШҮҮЛЭХ, НЭР ДЭВШИГЧИЙГ БҮРТГЭХ

24 дүгээр зүйл.Нэр дэвшүүлэх нийтлэг журам

24.1.Сонгуульд оролцох нам, эвсэл Хурлын төлөөлөгчид нэр дэвшүүлэх ажиллагааг сонгууль товлон зарласан өдрөөс хойш арав хоногийн дараа эхлүүлж, тав хоногийн хугацаанд дуусгана.

24.2.Сонгуульд бие даан нэрээ дэвшүүлэх ажиллагааг сонгууль товлон зарласан өдрөөс хойш тав хоногийн дараа эхлүүлж, арав хоногийн хугацаанд дуусгана.



24.3.Нэр дэвшигч нь энэ хуулийн 6.2-т зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

24.3.1.банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа, батлан даалтын өр болон хугацаа хэтэрсэн албан татварын өр төлбөргүй байх;

24.3.2.ял шийтгүүлж байгаагүй, эсхүл ял шийтгүүлж байсан боловч Эрүүгийн хуулийн 78.2, 78.3-т заасны дагуу ялгүй болсон буюу ялгүйд тооцогдсон байх;

24.3.3.нийслэлд нэгээс доошгүй жилийн хугацаанд байнга оршин сууж байгаа.

24.4.Төрийн жинхэнэ албан хаагч Хурлын төлөөлөгчид нэр дэвших бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна.

24.5.Энэ хуулийн 24.4-т зааснаас бусад этгээд Хурлын төлөөлөгчид нэр дэвшигчээр бүртгүүлэхээсээ өмнө ажил, албан тушаалаасаа түр чөлөөлөгдсөн байна.

24.6.Нэг намын гишүүнийг нөгөө намаас, эвслийн тухайд түүнд нэгдэн орсон намуудаас өөр намын гишүүнийг нэр дэвшүүлэхийг тус тус хориглоно.

24.7.Нэр дэвшигч нь нэгээс илүү тойрогт нэр дэвшиж болохгүй.

24.8.Нам, эвсэл аливаа нэг намын гишүүн бус иргэнийг түүний бичгээр гаргасан зөвшөөрлийн үндсэн дээр нэрийг нь дэвшүүлж болно.

24.9.Нэр дэвшигч нь тойрогт нэр дэвших, эсхүл нам, эвслийн жагсаалтаар нэр дэвшихийн аль нэгийг нь сонгож зөвшөөрөх бөгөөд эрх бүхий байгууллага энэ асуудлаар нэгэнт шийдвэр гаргасан бол түүнийг дахин өөрчлөхийг хориглоно.

24.10.Сонгуульд нэр дэвшигч нь Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшихийг хориглоно.

24.11.Энэ хуулийн 24.4-т зааснаар төрийн албанаас чөлөөлөгдсөн иргэн төрийн албанд эргэж ороход Төрийн албаны тухай хуулийн⁶ 17 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

⁶Төрийн албаны тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн.



25 дугаар зүйл. Нам, эвслээс нэр дэвшүүлэх

25.1. Нам, эвсэл 30-аас илүүгүй хүнийг тойрогт, тухайн тойргийн мандатын тооноос хэтрэхгүй байхаар нэр дэвшүүлнэ.

25.2. Нам, эвсэл 15-аас илүүгүй хүнийг дараалалд оруулсан жагсаалтаар нэр дэвшүүлнэ.

25.3. Энэ хуулийн 25.1, 25.2-т заасан нэр дэвшигчид давхардсан байж болохгүй бөгөөд нам, эвслээс нэр дэвшүүлэх асуудлыг нам, эвслийн эрх бүхий төлөөллийн байгууллага шийдвэрлэнэ.

25.4. Энэ хуулийн 25.2-т заасан дарааллыг энэ хуулийн 25.3-т заасан эрх бүхий төлөөллийн байгууллагын хуралдаанд оролцогчдоос нэр дэвшигч бүрийн авсан саналын тоо, хувиар эрэмбэлэн гаргана.

25.5. Нам, эвслээс нэр дэвшигчдийн 20-оос доошгүй хувь нь эмэгтэйчүүдийн төлөөлөл байна.

25.6. Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан нийтлэг журмаас гадна Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27.4-27.7-д заасан журмын холбогдох заалтыг баримтална.

26 дугаар зүйл. Бие даан нэрээ дэвшүүлэх

26.1. Бие даан нэрээ дэвшүүлэгч нь энэ хуулийн 11.2-т заасан тойрогт нэрээ дэвшүүлнэ.

26.2. Бие даан нэрээ дэвшүүлэгч нь нийслэлд тухайн тойргийн сонгуулийн эрх бүхий 200-аас доошгүй дэмжигч-сонгогчдын гарын үсгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтын дагуу зуруулж, Нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлнэ.

26.3. Бие даан нэрээ дэвшүүлэгч нь энэ хуулийн 26.2-т заасан маягтад гарын үсэг зуруулахдаа тухайн тойрогт хамрагдсан засаг захиргааны нэгж бүрийн сонгогчийн дэмжлэгийг авсан байвал зохино.

26.4. Энэ хуулийн 26.2-т заасан маягтад дэмжигч-сонгогчдын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаягийг гаргацтай, тодорхой бичсэн байна.

26.5. Нэр дэвшигчийг дэмжсэн дэмжигч-сонгогчдын гарын үсэг үнэн зөв эсэхийг тухайн хэсгийн хороо сонгогчдын иргэний баримт бичиг, хаягийн бүртгэлтэй тулгах буюу шаардлагатай бол дэмжигч-сонгогчтой



уулзаж нягтлан шалгах бөгөөд гарын үсгийг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдвол тухайн нэр дэвшигчийг Нийслэлийн сонгуулийн хорооны шийдвэрээр нэр дэвшигчдийн жагсаалтаас хасна.

27 дугаар зүйл.Нэр дэвшигчийг бүртгэх

27.1.Нэр дэвшигчийг нийслэлийн сонгуулийн хороо бүртгэнэ.

27.2.Нэр дэвшүүлсэн нам, эвсэл нь энэ хуулийн 24.1-д заасан нэр дэвшүүлэх ажиллагаа дууссан өдрөөс хойш хоёр хоногийн хугацаанд багтаан нэр дэвшигчтэй холбогдсон дараах баримт бичгийг Нийслэлийн сонгуулийн хороонд ирүүлнэ:

27.2.1.нэр дэвшүүлсэн тухай шийдвэр, тэмдэглэл;

27.2.2.нийт нэр дэвшигчийн жагсаалт, нэр дэвшигч бүрийн бичгээр өгсөн зөвшөөрөл;

27.2.3.нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлэг;

27.2.4.энэ хуулийн 24.3.1-д заасан өр төлбөргүй болох тухай нэр дэвшигчийн мэдүүлэг, эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

27.2.5.энэ хуулийн 24.3.2-т заасныг нотолсон цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

27.2.6.энэ хуулийн 24.4, 24.5-д заасан этгээдийн тухайд төрийн албанаас чөлөөлөгдсөн тухай болон ажил, албан тушаалаасаа түр чөлөөлөгдсөн тухай эрх бүхий байгууллагын шийдвэр;

27.2.7.нэр дэвшигчийн намтар.

27.3.Бие даан нэрээ дэвшүүлэгч нь энэ хуулийн 27.2-т заасан хугацаанд багтаан энэ хуулийн 27.2.3-27.2.7-д заасан баримт бичиг болон дэмжигч-сонгогчдын гарын үсэг цуглуулсан маягт, нэрээ дэвшүүлснээ илэрхийлсэн мэдэгдлийн хамт Нийслэлийн сонгуулийн хороонд ирүүлнэ.

27.4.Энэ хуулийн 27.2.4-т заасан тодорхойлолтыг Улсын дээд шүүх, энэ хуулийн 27.2.5-д заасан тодорхойлолтыг цагдаагийн төв байгууллага нэр дэвшигч тус бүрээр гаргаж, Нийслэлийн сонгуулийн хороонд сонгууль товлон зарласан өдрөөс хойш 25 хоногийн дотор албан бичгээр хүргүүлнэ.

27.5.Нийслэлийн сонгуулийн хороо нэр дэвшигчийг бүртгэхдээ нам, эвсэл болон нэр дэвшигчийн ирүүлсэн баримт бичиг үнэн зөв, гүйцэд эсэх, нэр дэвшүүлэх үйл ажиллагаа хуулийн дагуу явагдсан эсэхийг нягтлан шалгана.



27.6. Нийслэлийн сонгуулийн хороо бие даан нэр дэвшигчийн дэмжигч-сонгогчдын мэдээлэл үнэн зөв эсэхийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гаргасан сонгогчдын нэрийн жагсаалт, оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй түүвэрлэн тулгах буюу шаардлагатай бол тухайн иргэнтэй уулзаж нягтлан шалгах бөгөөд уг ажлыг нийслэлийн тойргийн хороогоор гүйцэтгүүлж болно.

27.7. Нийслэлийн сонгуулийн хороо энэ хуулийн 27.2, 27.3-т заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш тав хоногийн дотор нэр дэвшигчээр бүртгэх эсэх тухай асуудлыг шийдвэрлэнэ.

27.8. Энэ хуульд зааснаас бусад нэр дэвшигчийг бүртгэхтэй холбогдсон бусад харилцаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан холбогдох журмыг баримтална.

28 дугаар зүйл. Нөхөн нэр дэвшүүлэх

28.1. Нам, эвслээс нэр дэвшигч нас барсан, эсхүл шүүхээр ял шийтгүүлсэн тохиолдолд тухайн нам, эвсэл нь өөр хүнийг нөхөн нэр дэвшүүлэх шийдвэрээ Нийслэлийн сонгуулийн хороонд санал авах өдрөөс 20 хоногийн өмнө ирүүлж, энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан журмын дагуу бүртгүүлж болно.

28.2. Нам, эвсэл энэ хуулийн 28.1-д зааснаас бусад тохиолдолд нөхөн нэр дэвшүүлэхийг хориглоно.

29 дүгээр зүйл. Нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах

29.1. Нэр дэвшигч энэ хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлж, зохих журмын дагуу нийтэд зарлагдсаны дараа түүнийг нэр дэвшигчийн нэрийн жагсаалтаас хасах талаарх энэ хуульд заасан үндэслэл тогтоогдвол Нийслэлийн сонгуулийн хороо энэ тухай шийдвэр гаргаж, нийтэд мэдээлнэ.

29.2. Энэ хуулийн 29.1-д заасан Нийслэлийн сонгуулийн хорооны шийдвэрийн талаар маргаан гарвал энэ хуулийн Арван нэгдүгээр бүлэгт заасан харьяалал, журмын дагуу шийдвэрлэнэ.

30 дугаар зүйл. Нэр дэвшигчид туслах

30.1. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол нэр дэвшигчид туслахтай холбогдсон харилцаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан журмыг баримтална.



30.2.Нэр дэвшигч нь 500 сонгогч тутамд нэгээс илүүгүй шадар туслагч, эсхүл ухуулагчтай байна.

31 дүгээр зүйл.Нэр дэвшигчийн үйл ажиллагааны баталгаа

31.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол нэр дэвшигчийн үйл ажиллагааны баталгаатай холбогдсон бусад харилцаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

31.2.Гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу гэмт хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд нэр дэвшигчийг Нийслэлийн сонгуулийн хорооны зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл ногдуулах, орон байр, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийх, түүнчлэн захиргааны санаачилгаар ажлаас халахыг хориглоно.

31.3.Энэ хуулийн 31.2-т заасныг зөрчсөн этгээдэд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 33.4, 33.5-д заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР, СУРТАЛЧИЛГАА

32 дугаар зүйл.Сонгуулийн мөрийн хөтөлбөр

32.1.Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байна.

32.2.Нам, эвслээс нэр дэвшигч нь тухайн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрөөс өөр бие даасан сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байхыг хориглоно.

32.3.Энэ хуулийн 32.1-д заасан сонгуулийн мөрийн хөтөлбөрт мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгөтэй холбогдсон эрх олгох, уул уурхай, газрын тос, эрдэс баялгийн болон бусад салбарын орлогоос иргэдэд аливаа хишиг, хувь, тэдгээртэй адилтгах бусад зүйл хүртээх, эсхүл зээлийн болон бусад өр төлбөрийг хүчингүйд тооцох, хөрвүүлэх, түүнчлэн үнэ төлбөргүй, эсхүл хямдралтай үнээр үйлчилгээ үзүүлэх, эсхүл ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт авахаар тусгахыг хориглоно.

32.4.Нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээ тусгагдсан тохиолдолд түүнийг



хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд⁷ заасан төсвийн тусгай шаардлагад нийцсэн байна.

32.5.Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг хөндлөнгийн хяналтын байгууллагаар хянуулсан байна.

32.6.Энэ хуулийн 32.2, 32.3-т заасныг зөрчсөн нь тухайн нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах, нам, эвслийг сонгуульд оролцохоор бүртгэсэн тухай шийдвэрийг хүчингүйд тооцох үндэслэл болох бөгөөд уг шийдвэрийг Нийслэлийн сонгуулийн хороо нийтэд мэдээлнэ.

33 дугаар зүйл. Сонгуулийн сурталчилгаа

33.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол сонгуулийн сурталчилгаа явуулахад нам, эвсэл, нэр дэвшигч, сонгуулийн хороод болон бусад этгээд нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн холбогдох заалтыг баримтална.

33.2.Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө танилцуулсан хоёр хэвлэлийн хуудас бүхий сонин, хэвлэл, нэг хэвлэлийн хуудас бүхий ухуулах болон зурагт хуудас, нэр дэвшигчийн намтар, бусад сурталчилгааны материалыг нэг хэвлэлийн хуудаст тус тус багтаана.

33.3.Бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө танилцуулсан нэг хэвлэлийн хуудас бүхий сонин, хэвлэл, нэг хэвлэлийн хуудас бүхий ухуулах болон зурагт хуудас, нэр дэвшигчийн намтар, бусад сурталчилгааны материалыг нэг хэвлэлийн хуудаст тус тус багтаана.

33.4.Энэ хуулийн 33.2, 33.3-т заасан хязгаарлалтын дүнг хэвлэмэл байдлаар сонгогчдод тараах тухайн төрлийн хэвлэлийн нийлбэрээр тооцно.

33.5.Хурлын Тэргүүлэгчид нь радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийг батлахдаа нам, эвсэл, нэр дэвшигч бүрд тэнцүү хугацаа ногдохоор тооцож, холбогдох шийдвэр гаргаж мөрдүүлнэ.

33.6.Энэ хуулийн 33.5-д заасан сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийг бусад нам, эвсэл, нэр дэвшигчид шилжүүлэхийг хориглоно.

⁷Төсвийн тогтвортой байдлын тухай хууль –“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.



33.7.Олон нийтийн радио, телевизээр сонгуулийн аливаа сурталчилгааны нэвтрүүлгийг нэвтрүүлэхийг хориглоно.

33.8.Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевизээр сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийг төлбөртэй нэвтрүүлж болох бөгөөд тухайн радио, телевизийн сонгуулийн сурталчилгааны төлбөртэй нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт хоёр цагаас илүүгүй байна.

33.9.Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевиз нь нэгээс илүү сувагтай бол сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийг зөвхөн агаарын долгион ашигладаг үндсэн сувгаар нэвтрүүлнэ.

33.10.Сонгуулийн сурталчилгааны уриалга, ухуулах болон зурагт хуудас, зарлал, самбарыг гудамж, талбай болон олон нийтийн газарт байрлуулах байршлыг нам, эвсэл, нэр дэвшигчдийн эрх тэгш байдлыг хангах зарчмыг баримтлан сонгуулийн жилийн тавдугаар сарын арван тавны дотор тухайн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид тогтооно.

33.11.Нийслэлийн сонгуулийн хороо болон нийслэлийн тойргийн хороо сонгуулийн сурталчилгааны тэнцвэрт байдалд олон нийтийн оролцоотойгоор хяналт тавьж, энэ асуудлаар нам, эвсэл, нэр дэвшигч, байгууллага, иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэнэ.

33.12.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 35.15.1, 35.18.10-т заасныг зөрчиж сонгогчид бэлэн мөнгө, эд бараа тараасныг сонгогч баримттайгаар сонгуулийн хороонд мэдэгдсэнийг тухайн сонгуулийн хороо холбогдох байгууллагад шилжүүлэх бөгөөд уг асуудлыг холбогдох байгууллага үндэслэлтэй болохыг нь тогтоосон тохиолдолд Нийслэлийн сонгуулийн хороо тухайн сонгогчид бэлэн мөнгө болон эд барааны үнийн дүнг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгож, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

33.13.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлд зааснаар нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах, нам, эвслийг сонгуульд оролцохоор бүртгэсэн тухай шийдвэрийг хүчингүйд тооцох шийдвэрийг Нийслэлийн сонгуулийн хороо гаргаж, нийтэд мэдээлнэ.

33.14.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлд заасныг зөрчиж сонгогчид мөнгө, эд зүйл тараасан нь тухайн нэр дэвшигч Хурлын төлөөлөгчөөр сонгогдсонд тооцогдож, Хурлын төлөөлөгчийн түр үнэмлэх авснаас хойш тогтоогдвол тухайн Хурлын



төлөөлөгчөөр сонгогдсонд тооцогдсон этгээдийн Хурлын төлөөлөгчийн түр үнэмлэхийг Нийслэлийн сонгуулийн хороо хүчингүй болгоно.

33.15.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 35.20-д заасныг зөрчсөн нь нэр дэвшигч, нам, эвслийг сонгуульд оролцохоор бүртгүүлснээс хойш тогтоогдсон бол нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах, нам, эвслийг сонгуульд оролцохоор бүртгэсэн тухай шийдвэрийг хүчингүйд тооцох шийдвэрийг Нийслэлийн сонгуулийн хороо гаргаж, нийтэд мэдээлнэ.

34 дүгээр зүйл.Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх

34.1.Нам, эвсэл, нэр дэвшигч сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийхтэй холбогдсон харилцаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

НАЙМДУГААР БҮЛЭГ СОНГУУЛИЙН ЗАРДАЛ

35 дугаар зүйл.Сонгуулийн зардал

35.1.Хурлын Тэргүүлэгчид тойрогт нэг нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тухайн тойргийн нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, хүн амын тоо зэргийг харгалзан тойрог тус бүрээр, түүнчлэн нам, эвслийн нэрийн жагсаалтаар нэр дэвшигчдийн сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг санал авах өдрөөс 50-аас доошгүй хоногийн өмнө тус тус тогтооно.

35.2.Энэ хуулийн 35.1-д заасан сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээнд багтаан нам, эвслээс нэр дэвшигчийн сонгуулийн зардлыг тухайн нам, эвсэл болон нэр дэвшигч тус тус хариуцах бөгөөд бие даан нэр дэвшигч сонгуулийн зардлаа өөрөө хариуцна.

35.3.Энэ хуулийн 35.1-д заасан сонгуулийн зардлын дээд хэмжээг хэтрүүлсэн нам, эвслийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван таваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нэр дэвшигчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

36 дугаар зүйл.Сонгуулийн зардлын данс

36.1.Нам, эвсэл нэр дэвшигчдээ Нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлснээс хойш гурав хоногийн дотор нам, эвслийн нэрийн



жагсаалтаар нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын нэг дансыг банкинд нээлгэн, Нийслэлийн сонгуулийн хороо болон орон нутгийн төрийн аудитын байгууллагад бичгээр мэдэгдэж, нийтэд зарлана.

36.2.Тойрогт нэр дэвшүүлсэн нам, эвсэл нь нэр дэвшигч тус бүр дээр, түүнчлэн бие даан нэр дэвшигч нь өөрийн сонгуулийн зардлын дансыг Нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлснээс хойш гурав хоногийн дотор банкинд нээлгэн, Нийслэлийн сонгуулийн хороо болон орон нутгийн төрийн аудитын байгууллагад бичгээр мэдэгдэж, нийтэд зарлана.

36.3.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол сонгуулийн зардлын данстай холбогдсон бусад харилцаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

37 дугаар зүйл. Сонгуулийн хандив

37.1.Сонгуулийн хандивтай холбогдсон харилцаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

38 дугаар зүйл. Сонгуулийн зардлын тайлан гаргах

38.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол нам, эвсэл, нэр дэвшигч, Нийслэлийн сонгуулийн хороо нь сонгуулийн зардлын тайлан гаргахтай холбогдсон харилцаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

38.2.Нам, эвслээс нэр дэвшигч нь санал хураалт дууссан өдрөөс хойш 15 хоногт багтаан өөрийн сонгуулийн зардлын тайлангаа нам, эвсэлдээ гаргаж өгөх бөгөөд нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайланг санал хурааж дууссан өдрөөс хойш нэг сарын дотор гаргаж, Нийслэлийн сонгуулийн хороонд ирүүлнэ.

38.3.Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал нь уг дансны бүх гүйлгээг нэгтгэсэн тайлан гаргаж, энэ хуулийн 38.2-т заасан хугацаанд Нийслэлийн сонгуулийн хороонд ирүүлнэ.

38.4.Нийслэлийн сонгуулийн хороо зардлын тайланг хянаж, санал хураалт дууссан өдрөөс хойш 45 хоногийн дотор дүнг нийтэд мэдээлэх ба хоёр зуун мянга, түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, таван зуун мянга, түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд зарлана.



38.5.Нийслэлийн сонгуулийн хороо шаардлагатай гэж үзвэл нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлийг төрийн аудитын орон нутгийн байгууллагаар шалгуулж, дүгнэлт гаргуулна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ САНАЛ АВАХ, СОНГУУЛИЙН ДҮН ГАРГАХ, ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙГ БҮРТГЭХ

39 дүгээр зүйл.Санал авах газар, хугацаа

39.1.Сонгуулийн санал авах газар, хугацаатай холбогдсон харилцаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

40 дүгээр зүйл.Саналын хуудас

40.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол саналын хуудастай холбогдсон бусад харилцаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

40.2.Сонгуулийн саналын хуудас нь Улсын Их Хурлын сонгуулийн саналын хуудастай нэг хуудас байна.

40.3.Саналын хуудас нь тойрогт нэр дэвшигчдийн нэрийг бичсэн болон нам, эвслийн нэрийг бичсэн хоёр хэсэг бүхий нүүр байх бөгөөд энэ нь Улсын Их Хурлын сонгуулийн саналын хуудасны ар нүүрт байрлана.

40.4.Нийслэлийн сонгуулийн хороо саналын хуудаст бичигдэх сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн холбогдох мэдээлэл, тойрогт болон нам, эвслийн жагсаалтаар нэр дэвшигчдийн мэдээллийг нэр дэвшигчдийн бүртгэл дууссаны дараа Сонгуулийн ерөнхий хороонд нэн даруй хүргэсэн байна.

40.5.Сонгуулийн ерөнхий хороо саналын хуудсыг эрхлэн хэвлүүлж, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 42.10-т заасан журмын дагуу хэсгийн хороонд албан ёсоор хүлээлгэн өгнө.

41 дүгээр зүйл.Санал авах ажиллагаа

41.1.Санал авах ажиллагаатай холбогдсон харилцаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 43 дугаар зүйлд заасан журмыг баримтална.



42 дугаар зүйл. Сонгуулийг ажиглах

42.1. Сонгуулийг ажиглахтай холбогдсон харилцаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

43 дугаар зүйл. Сонгогч саналаа өгөх

43.1. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол сонгогч саналаа өгөхтэй холбогдсон бусад харилцаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

43.2. Сонгогч нь саналын хуудасны тойрогт нэр дэвшигчдийн нэрийг бичсэн хэсэг дэх өөрийн дэмжиж байгаа, тухайн тойрог ногдсон мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугаарыг тэмдэглэнэ.

43.3. Сонгогч нь саналын хуудасны нам, эвслийн нэрийг бичсэн хэсэг дэх өөрийн дэмжиж байгаа зөвхөн нэг нам, эсхүл эвслийн нэрийн өмнөх дугаарыг тэмдэглэнэ.

44 дүгээр зүйл. Санал тоолох

44.1. Сонгуулийн санал тоолохтой холбогдсон харилцаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

45 дугаар зүйл. Санал болон саналын хуудсыг хүчингүйд тооцох

45.1. Санал болон саналын хуудсыг хүчингүйд тооцохтой холбогдсон харилцаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

46 дугаар зүйл. Сонгуулийн дүн гаргах, мэдээлэх

46.1. Нийслэлийн тойргийн хороо нь хэсгийн хороодоос ирүүлсэн санал хураалтын дүнг нэгтгэн, тухайн тойргийн санал хураалтын эцсийн дүнг тойрогт нэр дэвшигчдийн авсан санал, нам, эвслийн авсан санал гэсэн ангиллаар гаргана.

46.2. Нийслэлийн тойргийн хороо тойрогт нэр дэвшигчдийг авсан саналын тоогоор нь эрэмбэлэн дараалалд оруулан жагсаалт /цаашид “А” жагсаалт” гэх/-ыг гаргаж, нам, эвслийн авсан саналын хамт Нийслэлийн сонгуулийн хороонд хүргэнэ.



46.3. Нийслэлийн сонгуулийн хороо нийслэлийн тойргийн хороодоос ирүүлсэн тойрог бүрийн “А” жагсаалтыг үндэслэн тухайн тойргийн хамгийн олон хувийн санал авсан, мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчдийг Хурлын төлөөлөгчөөр шууд сонгогдсонд тооцно.

46.4. Энэ хуулийн 46.2-т заасан “А” жагсаалт дахь хамгийн олон хувийн санал авсан нэр дэвшигчдийг тойрогт ногдох мандатын тоогоор таслахад тухайн таслагаа дахь мандатад хуваарилагдах нэр дэвшигчдийн сонгогчдоос авсан саналын тоо нь тэнцсэн тохиолдолд тэдгээр нэр дэвшигчдийг дахин санал хураалтад оруулж хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг Хурлын төлөөлөгчөөр сонгогдсонд тооцно.

46.5. Нийслэлийн сонгуулийн хороо нийслэлийн тойргийн хороодоос ирүүлсэн нам, эвсэлд өгсөн сонгогчдын саналын тоог үндэслэн сонгуулийн дүнг нийслэлийн хэмжээгээр дараах байдлаар нэгтгэн гаргаж, нам, эвсэлд суудлыг хуваарилна:

46.5.1. нам, эвсэл тус бүрийн авсан нийт саналын тоог гаргаж, бүх нам, эвслийн авсан нийт саналын таваас доошгүй хувийн санал авсан нам, эвслийг авсан саналын хувиар нь дараалалд оруулан жагсаалт /цаашид ““Б” жагсаалт” гэх/-ыг гаргах;

46.5.2. энэ хуулийн 46.5.1-д заасан таван хувийн босгыг даваагүй нам, эвслийн авсан нийт саналын хувийг тэнцүү хэмжээгээр хуваан “Б” жагсаалтад орсон нам, эвсэл тус бүрийн авсан саналын хувь дээр нэмж тооцох;

46.5.3. “Б” жагсаалтад орсон нам, эвслийн энэ хуулийн 46.5.2-т заасан саналын хувиудын нийлбэрийг 15-д хувааж нэг суудалд ногдох хувийг тооцох;

46.5.4. “Б” жагсаалтад орсон нам, эвсэл тус бүрийн энэ хуулийн 46.5.2-т заасан саналын хувийг энэ хуулийн 46.5.3-т заасан нэг суудалд ногдох хувьд хувааж Хурлын төлөөлөгчийн 15 суудлыг их үлдэгдлийн зарчмаар хувь тэнцүүлэн хуваарилах;

Тайлбар: “Их үлдэгдлийн зарчмаар хувь тэнцүүлэн хуваарилах” гэж нам, эвслийн авсан саналын хувьд ногдох суудлын тоог бутархай нарийвчлалтай гаргаж, эхний ээлжид бүхэл хэсэгтэй нь тэнцэх суудлыг хуваарилах, хэрэв хуваарилагдаагүй суудал үлдвэл хамгийн их үлдэгдэл буюу бутархай хэсэгтэй нам, эвслээс нь эхлэн нэг нэгээр суудлыг нэмж хуваарилах замаар бүх суудлыг хуваарилж дуусгахыг ойлгоно.



46.5.5.энэ хуулийн 25.2-т заасан нэр дэвшигчдийн жагсаалтын эхнээс уг нам, эвсэлд энэ хуулийн 46.5.4-т заасны дагуу хуваарилсан суудлын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчдийг Хурлын төлөөлөгчөөр сонгогдсонд тооцох.

46.6.Нийслэлийн сонгуулийн хороо энэ хуулийн 46.3, 46.4, 46.5.5-д заасны дагуу Хурлын төлөөлөгчөөр сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигчид Хурлын төлөөлөгчийн түр үнэмлэх олгоно.

46.7.Нийслэлийн сонгуулийн хороо сонгуулийн дүнг долоо хоногт багтаан хуралдаанаараа хэлэлцэж, Хурлын төлөөлөгчөөр сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт болон тэдгээрийн бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай шийдвэрийн төсөл боловсруулж шинээр сонгогдсон Хуралд өргөн мэдүүлж, энэ тухай Сонгуулийн ерөнхий хороо болон нийтэд долоо хоногийн дотор мэдээлнэ.

46.8.Санал хураалтын дүнгийн талаар маргаан гарвал Нийслэлийн сонгуулийн хороо санал авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ
САНАЛ ХУРААЛТ БОЛОН СОНГУУЛИЙГ ХҮЧИНГҮЙД ТООЦОХ,
ДАХИН САНАЛ ХУРААХ, ДАХИН СОНГУУЛЬ ЯВУУЛАХ,
ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙГ НӨХӨН СОНГОХ

47 дугаар зүйл.Хэсэгт явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцох, дахин санал хураах

47.1.Нийслэлийн тойргийн хороо дор дурдсан тохиолдолд хэсэгт явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцно:

47.1.1.байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон зэрэг хүндэтгэн үзэх шалтгаангүй байхад урьд нь зарласнаас өөр байранд, түүнчлэн зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар авснаас бусад тохиолдолд санал хураахаар зарласнаас өөр өдөр санал авсан;

47.1.2.санал авсан саналын хайрцгийг алдсан, үрэгдүүлсэн, эсхүл хуульд заасан цагаас өмнө түүнийг нээсэн;

47.1.3.сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн буюу сонгогчид хүч хэрэглэн дарамт үзүүлсэн аливаа үйлдэл нь сонгогчийн санал, санал хураалтын дүнг гажуудуулахад хүргэсэн;

47.1.4.сонгуулийн хороодын гишүүн, бусад байгууллагын албан тушаалтан сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах,



сонгогч шилжих, санал авах ажлыг зохион байгуулах, сонгогч санал өгөх, санал тоолох журмыг зөрчсөн нь тухайн тойргийн сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөхөөр бол;

47.1.5.тойрогт тухайн тойргийн сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн нийт сонгогчийн 50-аас дээш хувь нь оролцоогүй бол уг тойргийн 50-аас дээш хувь нь оролцоогүй хэсэг тус бүрд.

47.2.Нийслэлийн тойргийн хороо хэсэгт явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцвол энэ тухай шийдвэр гарснаас хойш долоо хоногийн дотор дахин санал хураалт явуулна.

47.3.Дахин санал хураалт явуулах шийдвэрийг нийслэлийн тойргийн хороо гаргах бөгөөд уг шийдвэрт санал авах байр, өдрийг заах ба түүнийг ажлын өдөр явуулж болно.

47.4.Санал хураалтыг хэсгийн хэмжээгээр хүчингүйд тооцсон бол тухайн хэсгийн нийт сонгогч, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар хураасан саналыг хүчингүйд тооцсон бол уг саналын хайрцагт саналаа өгсөн сонгогчдыг дахин санал хураалтад оролцуулна.

47.5.Дахин санал хураах ажиллагааг дуустал сонгуулийн сурталчилгаа хийхийг хориглоно.

47.6.Энэ хуулийн 47.5-д заасныг зөрчсөн нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагч, дэмжигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нам, эвсэл, бусад байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

48 дугаар зүйл.Тойрогт явуулсан сонгуулийг хүчингүйд тооцох, дахин сонгууль явуулах

48.1.Энэ хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу хэсэгт явуулсан дахин санал хураалт хүчингүй болсон бөгөөд тэр нь сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөхөөр байвал Нийслэлийн сонгуулийн хороо тойрогт явуулсан сонгуулийг хүчингүйд тооцож дахин сонгууль явуулах шийдвэр гаргана.

48.2.Дахин сонгуулийг тухайн сонгуулийг хүчингүйд тооцсон шийдвэр гарснаас хойш 14 хоногийн хугацаанд явуулна.



48.3.Дахин сонгууль явуулах шийдвэр гарсан бол сонгуулийн хороог шинэчлэн байгуулах, нэр дэвшүүлэх зэрэг уг сонгуулийг бэлтгэн явуулах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийг баримтлан зохион байгуулна.

49 дүгээр зүйл.Хурлын төлөөлөгчийн орон гарсан суудлыг нөхөх болон Хурлын төлөөлөгчийг нөхөн сонгох

49.1.Тойргоос сонгогдсон Хурлын төлөөлөгч нас барсан, түүнчлэн өөр ажилд шилжсэн, эрүүл мэндийн байдал зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүсэлтээрээ чөлөөлөгдсөн, эсхүл түүнийг Хурлын төлөөлөгчөөс эгүүлэн татсан бол нөхөн сонгууль явуулна.

49.2.Энэ хуулийн 46.5.5-д заасны дагуу нэр дэвшигчдийн жагсаалтаас сонгогдсон Хурлын төлөөлөгч нас барсан, түүнчлэн өөр ажилд шилжсэн, эрүүл мэндийн байдал зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүсэлтээрээ чөлөөлөгдсөн, эсхүл түүнийг Хурлын төлөөлөгчөөс эгүүлэн татсан бол Хурлын төлөөлөгчийн орон гарсан суудалд нам, эвслийн жагсаалтаас нэр дэвшигчдийн жагсаалтын тухайн нам, эвслийн дараагийн дэс дугаарт эрэмбэлэгдсэн эхний нэр дэвшигчийг Хурлын төлөөлөгчөөр нөхөн сонгогдсонд тооцох бөгөөд тухайн жагсаалтад нэр дэвшигч үлдээгүй бол нөхөн сонгууль явуулна.

49.3.Хурлын төлөөлөгч нас барсан тохиолдолд Хурлын Тэргүүлэгчид уул өдрөөс хойш 50 хоногийн дотор нөхөн сонгуулийг товлон зарлана.

49.4.Хурлын төлөөлөгч нас барснаас бусад энэ хуулийн 49.1, 49.2-т заасан нөхцөл байдал үүссэний улмаас нөхөн сонгууль явуулах бол Хурлын Тэргүүлэгчид уг нөхцөл байдал үүссэнээс хойш 14 хоногийн дотор сонгуулийг товлон зарлаж, 30 хоногийн дотор Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон энэ хуулийн холбогдох заалтыг баримтлан дор дурдсан хугацаанд зохион байгуулна:

49.4.1.хэсгийг санал авах өдрөөс 25 хоногийн өмнө, Нийслэлийн сонгуулийн хороог 20 хоногийн өмнө, нийслэлийн тойргийн хороог 17 хоногийн өмнө, хэсгийн хороог 15 хоногийн өмнө тус тус байгуулах;

49.4.2.нэр дэвшүүлэх ажлыг нөхөн сонгууль товлон зарласан өдрөөс хойш тав хоногийн дараа эхлүүлж, тав хоногийн хугацаанд дуусгах;



49.4.3.энэ хуулийн 49.4.2-т заасан хугацаанаас хойш тав хоногийн хугацаанд нэр дэвшигчийг бүртгэх;

49.4.4.сонгогчдын нэрийн жагсаалтыг энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан журмын дагуу үйлдэж, санал авах өдрөөс 12 хоногийн өмнө хэсгийн хороонд өгөх;

49.4.5.хэсгийн хороо энэ хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг тулгаж, санал авах өдрөөс арваас доошгүй хоногийн өмнө өөрийн байранд ил тавьж, сонгогчдод чөлөөтэй танилцах бололцоо олгох.

49.5.Хурлын орон гарсан төлөөлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахад нэг жил хүрэхгүй хугацаа үлдсэн бол орон гарсан суудлыг нөхөхгүй.

49.6.Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахад нэг жил хүрэхгүй хугацаа үлдсэн үед орон гарсан бол нөхөн сонгууль явуулахгүй.

49.7.Хурлын нөхөн сонгогдсон төлөөлөгчийн бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

49.8.Нийслэлийн сонгуулийн хороо ээлжит болон ээлжит бус, нөхөн сонгууль явагдсаны дараа тухайн сонгуультай холбогдох баримт бичгийг Хурлын Тэргүүлэгчдэд хүлээлгэж өгнө.

**АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧИД
ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА, ГОМДОЛ, МАРГААН
ШИЙДВЭРЛЭХ ХАРЬАЛАЛ, ЖУРАМ**

**50 дугаар зүйл. Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчигчид
хүлээлгэх хариуцлага**

50.1. Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд энэ хууль болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

50.2. Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол гэм буруутай этгээдэд Эрүүгийн хуульд⁸ заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

⁸Эрүүгийн хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн.



50.3. Сонгуулийн үйл ажиллагааны явцад сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад эд хөрөнгийн болон бусад хохирол учирсан бол гэм буруутай этгээдэд Иргэний хууль⁹ болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

50.4. Энэ хуульд заасан зөрчил гаргаж захиргааны хариуцлага хүлээсэн нь уг этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

51 дүгээр зүйл. Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн тухай гомдол, маргааныг шийдвэрлэх харьяалал

51.1. Энэ хуульд сонгуулийн хороод харьяалан шийдвэрлэхээр заасан зөрчил гарсан бол гомдлыг холбогдох сонгуулийн хороонд гаргана.

51.2. Энэ хуульд заасан захиргааны шийтгэлийг дүүргийн шүүхийн шүүгч ногдуулах ба түүнд давж заалдсан гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд¹⁰ заасны дагуу нийслэлийн шүүх хянан шийдвэрлэнэ.

51.3. Энэ хуулийн холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд эрүүгийн болон иргэний хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байвал уг асуудлыг Эрүүгийн байцаан шийтгэх хууль¹¹ болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журам, харьяаллын дагуу шийдвэрлэнэ.

51.4. Сонгуулийн тухай хууль тогтоомжид заасны дагуу сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг тухайн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнээс хасах тухай шийдвэрийг дээд шатных нь сонгуулийн хороо гаргах бөгөөд уг шийдвэр нь Төрийн албаны тухай хуульд заасны дагуу эрх бүхий албан тушаалтан тухайн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнээр ажилласан төрийн албан хаагчийг төрийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах үндэслэл болно.

52 дугаар зүйл. Сонгуулийн хороодын үйл ажиллагаатай холбогдох бусад маргааныг хянан шийдвэрлэх

52.1. Сонгуулийн тухай хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол сонгуулийн зохион байгуулалтын асуудлаар гаргасан хэсгийн хороо

⁹Иргэний хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

¹⁰Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

¹¹Эрүүгийн байцаан шийтгэх хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 6 дугаарт нийтлэгдсэн.



болон нийслэлийн тойргийн хорооны шийдвэрийн талаар Нийслэлийн сонгуулийн хороонд гомдол гаргаж болох бөгөөд Нийслэлийн сонгуулийн хороо гомдлыг хүлээж авснаас хойш ажлын гурван өдрийн дотор хянан шийдвэрлэж, гомдол гаргагчид бичгээр хариу мэдэгдэнэ.

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ БУСАД АСУУДАЛ

53 дугаар зүйл. Сонгуулийн үйл ажиллагааг автоматжуулах

53.1. Сонгуульд сонгуулийн хороодын ажлыг хөнгөвчилж автоматжуулах, сонгогчдын нэрийн жагсаалтыг хянан нягтлах, сонгуулийн явцын мэдээллийг үнэн зөв, шуурхай гаргах, санал тоолох ажиллагаанд хүний хүчин зүйлсийн сөрөг нөлөөллийг арилгах, ажиглагчид ил тод болгох зорилгоор хэсгийн хороод сонгуулийн автоматжуулсан системийг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэглэж болно.

54 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

54.1. Энэ хуулийг 2012 оны 4 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 04 дүгээр
сарын 27-ны өдөр

Улаанбаатар
хот

ОРОН НУТГИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.4.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1.5, 12.1.6, 12.1.12, 12.1.13, 12.1.15 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1.6, 13.1.8 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.10 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.10, 25.13 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг, 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсгийн “аймаг, нийслэлийн” гэснийг “аймгийн” гэж, 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 12.1, 12.2 дахь хэсэг, 37 дугаар зүйлийн 37.6 дахь хэсэг, 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийн “Аймаг, нийслэлийн” гэснийг “Аймгийн” гэж, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “аймаг, нийслэлд” гэснийг “аймагт” гэж тус тус өөрчилсүгэй.



2 дугаар зүйл. Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт, 4 дүгээр зүйлийн 4.2, 4.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.1.3, 10.2.1, 10.2.2, 10.2.6, 10.2.7 дахь заалт, 10.7, 10.8 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1.9 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.8, 15.13 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.8 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.3, 21.8, 21.9 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1, 23.4 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.2-24.4 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1-25.4, 25.6-25.9, 25.11, 25.14, 25.15 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.2-26.5 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.7, 30.8, 30.17 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.2, 35.5, 35.7, 35.10 дахь хэсэг, 37 дугаар зүйлийн 37.5, 37.10 дахь хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэг, 43 дугаар зүйлийн 43.1, 43.3, 43.5-43.7 дахь хэсэг, 45 дугаар зүйлийн 45.1.1 дэх заалт, 46 дугаар зүйлийн 46.3.1 дэх заалт, 46.5 дахь хэсэг, 49 дүгээр зүйлийн 49.5 дэх хэсгийн “нийслэл,” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 05 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар
хот

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгууль товлон зарлах тухай

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийг 2012 оны 5 дугаар сарын 07-ны өдрөөс товлон зарласугай.

2. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрийг 2012 оны 6 дугаар сарын 28-ны өдөр байхаар тогтоосугай.



3.Энэ тогтоолыг 2012 оны 5 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 2 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар
хот

Эрчим хүчний зохицуулах хорооны дүрэм батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 5.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан Эрчим хүчний зохицуулах газрыг Эрчим хүчний зохицуулах хороо болгон өөрчлөн байгуулж, тус хорооны дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Зарим байгууллагыг байгуулах, дүрэм батлах тухай” Засгийн газрын 2001 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 83 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ЭРДЭС БАЯЛАГ,
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД**

Д.ЗОРИГТ

Засгийн газрын 2012 оны 49 дүгээр
тогтоолын хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү дүрэм нь Эрчим хүчний зохицуулах хороо (цаашид "Хороо" гэх)-ны үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Хороо нь Эрчим хүчний тухай хуулийн 8.1-д заасны дагуу эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах, диспетчерийн зохицуулалт хийх үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий байгууллага мөн.



1.3. Хорооны үндсэн зорилго нь Эрчим хүчний тухай хуульд заасны дагуу эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хэрэглэгчийн тарифыг хянаж батлах, тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хүрээнд шударга өрсөлдөөнийг бий болгох нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

1.4. Хороо нь хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ төрийн байгууллага, нутгийн захиргааны болон бусад байгууллагатай хамтран ажиллана.

1.5. Хороо зохих журмын дагуу хийсэн тамга, хэвлэмэл хуудастай байна. Хороо нь өөрийн бэлгэдэлтэй байж болно.

Хоёр. Хорооны чиг үүрэг

2.1. Хороо нь Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйл, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5.6-д заасан бүрэн эрхийн хүрээнд дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. эрчим хүчний салбарын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах;

2.1.2. эрчим хүчний салбарт тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон холбогдох бусад хуулийн этгээд, иргэнээс тайлан, мэдээ, мэдээлэл, тодорхойлолт авах;

2.1.3. хорооны орон тооны бус гишүүд, Эрчим хүчний тухайн хуулийн 8.5-д заасан орон тооны бус зөвлөл болон орон нутгийн зохицуулах зөвлөлийн гишүүдэд олгох цалин, урамшууллын хэмжээг тогтоох, төсвийг батлах;

2.1.4. иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэх;

2.1.5. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

2.1.6. эрчим хүчний салбарын үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой хуульд заасан бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

2.1.7. хорооны үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэх санхүүгийн болон хүний нөөц, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

2.1.8. хууль тогтоомжид заасан бусад үйл ажиллагаа.



Гурав. Хорооны дарга, гишүүдийн эрх, үүрэг

3.1. Хорооны дарга дараахь эрх, үүрэгтэй байна:

3.1.1. Эрчим хүчний болон Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;

3.1.2. хороо, түүний ажлын албаны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах;

3.1.3. хорооны үйл ажиллагааны стратегийг тодорхойлох, биелэлтэд нь хяналт тавих;

3.1.4. хорооны ажлын албаны даргыг томилох, чөлөөлөх асуудлыг зохицуулах хорооны хуралд оруулах;

3.1.5. хорооны зорилго, зорилтыг хангах асуудлыг биечлэн хариуцаж зохион байгуулах;

3.1.6. эрчим хүчний зохицуулалт, үнэ тарифын талаар төрийн захиргааны төв байгууллага болон Засгийн газрыг мэдээллээр хангах;

3.1.7. хорооны хурлаар хэлэлцэх асуудлыг тогтоох, хурлыг товлох, даргалах;

3.1.8. хууль тогтоомж болон энэхүү дүрэмд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор тушаал гаргаж биелэлтийг хангуулах;

3.1.9. батлагдсан төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулах;

3.1.10. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

3.2. Хорооны гишүүн дараахь эрх, үүрэгтэй байна:

3.2.1. хорооны ажлын албаны дарга болон хэлтэс, нэгжийн удирдлагад үүрэг даалгавар өгөх, гүйцэтгэлд хяналт тавих;

3.2.2. хорооны хурлаар тодорхой асуудал хэлэлцүүлэх санал оруулах;

3.2.3. хурлаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан нэмэлт баримт бичиг шаардах буюу гаргаж өгөх.

3.3. Хорооны дарга, орон тооны хоёр гишүүн нь эрчим хүчний салбарт ажилласан дадлага туршлагатай, дээд боловсролтой, Монгол Улсын иргэн байна. Орон тооны бус хоёр гишүүн нь эрчим хүчний салбарын зохих мэдлэг, дадлага туршлагатай, дээд боловсролтой, Монгол Улсын иргэн байна.



3.4. Хорооны даргын эзгүйд түүнийг хорооны орон тооны гишүүнээр хамгийн олон жил ажилласан, хэрэв хорооны гишүүдийн ажилласан жил адил бол насаар ахмад гишүүн орлоно.

3.5. Хорооны дарга, гишүүд эрчим хүчний хяналтын улсын байцаагчийн эрхтэй байна.

3.6. Хорооны дарга, гишүүнийг дараахь тохиолдолд үүрэгт ажлаас нь чөлөөлнө:

3.6.1. томилогдсон хугацаа дууссан;

3.6.2. өөрөө хүсэлт гаргасан;

3.6.3. эрүүл мэндийн хувьд цаашид ажиллах боломжгүй болсон нь эрүүл мэндийн байгууллагаар тогтоогдсон;

3.6.4. хуульд заасан тэтгэвэрт тогтоолгох насанд хүрсэн;

3.6.5. хууль тогтоомж зөрчсөн нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон.

3.7. Хорооны дарга, гишүүдийг томилолтын хугацаа дуусахаас өмнө чөлөөлсөн тохиолдолд шинээр томилогдсон дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа нь өмнөх дарга, гишүүний үлдсэн хугацаатай адил байна.

Дөрөв. Хорооны зохион байгуулалт

4.1. Хорооны үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь зохицуулах хорооны хурал байна.

4.2. Зохицуулах хорооны хурлын шийдвэр тогтоол хэлбэртэй байх бөгөөд хурлын явцад тэмдэглэл хөтөлнө.

4.3. Хороо нь жил бүрийн I улиралд багтаан ажлын тайлан, төсвийн гүйцэтгэлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид тайлагнана.

Тав. Хорооны ажлын алба

5.1. Хорооны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий ажлын албаны бүтэц, орон тоог эрчим хүчний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн зохицуулах хорооны хурал тогтооно.

5.2. Ажлын алба нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.2.1. хорооны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах;



5.2.2. хорооны гишүүдийг холбогдох мэдээлэл, судалгаагаар хангах;

5.2.3. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны болон тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын талаар санал боловсруулах;

5.2.4. эрчим хүчний үнэ тарифын талаар баримтлах бодлого, чиглэлийг боловсруулах, хэрэгжүүлэх;

5.2.5. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн санхүү, эдийн засгийн байдал, үйл ажиллагааны зардалд дүн шинжилгээ хийх;

5.2.6. хорооны эрх хэмжээнд хамаарах асуудлаар холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын төсөл боловсруулах;

5.2.7. хорооны ажлын албаны хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, тэдний нийгмийн асуудлын талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх;

5.2.8. хорооны хурлыг сард 1-ээс доошгүй удаа хийж, шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг хуралдуулж болно;

5.2.9. хорооны тогтоолд хорооны дарга, гишүүд, хурлын тэмдэглэлд хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна;

5.2.10. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 2 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар
хот

Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн нэмэгдлийн хэмжээ тогтоох тухай

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 19, 21.1.1, Төрийн албаны тухай хуулийн 28.9-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Эрдэм шинжилгээний байгууллагын эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн нэмэгдлийн хэмжээг хавсралт ёсоор баталж, 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2.Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн нэмэгдэл олгоход шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж, хэрэгжилтэд нь



хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Д.Хаянхярваа, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД**

Ё.ОТГОНБАЯР

Засгийн газрын 2012 оны 50 дугаар
тогтоолын хавсралт

**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ ЗЭРЭГ ДЭВИЙН
НЭМЭГДЛИЙН ХЭМЖЭЭ**

№	Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэв	Үндсэн цалингаас тооцох хувь
1	Эрдэм шинжилгээний дэд зэрэг	10
2	Эрдэм шинжилгээний ахлах зэрэг	15
3	Эрдэм шинжилгээний тэргүүлэх зэрэг	20

Жич: Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг, дэвийг давхардуулан олгохгүй.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 2 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар
хот

**Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн
зөвлөгөөний зөвлөмжийг хэрэгжүүлэх арга
хэмжээний тухай**

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 10.1-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн улсын зөвлөгөөний зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэхүү тогтоолын хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай болон Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Т.БАДАМЖУНАЙ



Засгийн газрын 2012 оны 51 дүгээр
ТОГТООЛЫН ХАВСРАЛТ

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧДИЙН УЛСЫН ЗӨВЛӨГӨӨНИЙ ЗӨВЛӨМЖИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах яам, газар	Хамтран хэрэгжүүлэх яам, газар
Эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх чиглэлээр:				
1	Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах	2012-2013	ХХААХҮЯ, ХЗДХЯ	ЖДҮГ
2	Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах	2012-2013	ХХААХҮЯ	ЖДҮГ, МХҮНХ
3	Гаалийн болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас жижиг, дунд үйлдвэрийн зориулалттай тоног төхөөрөмжийг чөлөөлөх тухай хуулиудын үйлчлэх хугацааг 2016 он хүртэл сунгах тухай хуулийн төсөл боловсруулах	2012 оны I, II улиралд	ХХААХҮЯ, СЯ	ГЕГ, ЖДҮГ
4	Нэмэгдсэн өртгийн албан татварын босгыг 200 сая хүртэл төгрөг болгох, салбарын онцлогоор ялгавартай татвар тогтоох, татвараас чөлөөлөх эсхүл бага татвар тогтоох саналуудыг судалж, төсөл боловсруулах	2012 оны I улиралд	СЯ, ХХААХҮЯ	ЖДҮГ, ТЕГ, МАОЭНХ
5	Дотоодын үйлдвэрүүдэд нийлүүлсэн ноос, ноолууран бүтээгдэхүүн, импортлоор авч байгаа мод, модон материалыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, эсхүл бага татвар тогтоох саналыг судлах	2012-2014	СЯ, ХХААХҮЯ	ТЕГ, ЖДҮГ
6	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас 3-5 жилийн хугацаагаар чөлөөлөх, 50 сая хүртэлх төгрөгийн жилийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж, иргэнд ялгавартай, тогтмол татвар ногдуулах саналыг судлан төсөл боловсруулах	2012 оны I улиралд	СЯ, ХХААХҮЯ	ЖДҮГ, ТЕГ, МАОЭНХ
7	Жижиг, дунд, бичил, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд зориулан жил бүр 150.0 тэрбум төгрөгөөс доошгүй хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх асуудлыг судлан санал боловсруулах	2012-2016	СЯ, ХХААХҮЯ, ХЗДХЯ	ЖДҮГ, МАОЭНХ
8	Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг дэмжих, арьс шир, мап, сүү бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан малчдад мөнгөн урамшуулал олгох асуудлыг судалж, санал боловсруулах	2012 оны I, II улиралд	СЯ, ХХААХҮЯ	ЖДҮГ, АШУХ

9	Ахлын байр шинээр бий болгосон, хадгалсан аж ахуйн нэгж, ажил олгогчдод дэмжлэг үзүүлэх, бүсийн нэмэгдэл олгох саналыг судлах	2012-2016	СЯ, ХХААХҮЯ, НХХЯ	ЖДҮГ, МАОЭНХ
10	Боловсруулах үйлдвэр болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд ажиллагсдын ажлын норм, норматив, үнэлгээг боловсруулж, тэдэнд урамшуулал, эсхүл бүсийн нэмэгдэл олгох саналыг судалж, холбогдох баримт бичгийн төсөл боловсруулах	2012-2016	СЯ, ХХААХҮЯ, НХХЯ	ЖДҮГ, МАОЭНХ
11	Алслагдсан бус нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдэд цахилгаан, дулаан, тээврийн зардлын нөхөн төлбөр олгох саналыг судлах	2012-2014	СЯ, ЭБЭХЯ, ХХААХҮЯ, ЗТБХЯ	УХШХ, ЖДҮГ
12	Олон улсын хэмжээний мэргэжлийн уралдаан, тэмцээн, үзэсгэлэн яармагт амжилт үзүүлсэн ажилтныг урамшуулах эрх зүйн орчин бий болгох саналыг судлах	2012 оны I улиралд	СЯ, ХХААХҮЯ	ЖДҮГ
13	Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний зориулалтаар импортоор авч байгаа үндсэн болон туслах материалыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, хасалт хийх саналыг судлах	2012-2013	СЯ, ХЗДХЯ, ХХААХҮЯ	МАОЭНХ, МОНХ, ОНХ
14	Дотооддоо үйлдвэрлэж байгаа зарим бараа, бүтээгдэхүүний зах зээлийг хамгаалах зорилгоор импортын татварыг нэмэгдүүлэх, зарим бараанд тарифын болон тарифын бус зохицуулалт хийх зэрэг саналыг судлах	2012-2014	СЯ, ХХААХҮЯ	ЖДҮГ, ТЕГ, ГЕГ
15	Бичил болон өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх саналыг судлах	2012-2013	СЯ, НХХЯ, ХХААХҮЯ, ХЗДХЯ	МАОЭНХ
16	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр улс төрийн намуудтай санамж бичиг байгуулан ажиллах	2012	Холбогдох сайд нар	ХХААХҮЯ, ЖДҮГ
Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр:				
17	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, байгаль орчны хамгаалал хоёр үе шаттай Япон Улсын төслийн зээлийн тодорхой хувийг өрхийн хөгжлийг дэмжихэд чиглүүлэх	2012-2013	СЯ	ХХААХҮЯ
18	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, тухайлбал уул уурхай, томоохон төсөл, хөрөнгө оруулалтын гэрээ, баримт бичигт дотоодоос бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх талаар тусгаж байх	2012-2016	Холбогдох яамд	ЖДҮГ, АНЗДТГ
19	"Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2011 оны 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг	2012-2016	Холбогдох яамд	ЖДҮГ, АНЗДТГ,



	эрчимжүүлэх арга хэмжээ авах, хэрэгжилтийн явц, үр дүнг Засгийн газарт мэдээлэх			ЖДҮГ, ХЭДС, АНЗДТГ, мэргэжлийн холбоод
20	Хөдөөг хоршоолох аян өрнүүлэх санаачлагыг улсын хэмжээнд зохион байгуулж, хоршоодыг хөрөнгө оруулалт, санхүү зээл, татварын бодлогоор дэмжих, сургалт зохион байгуулах	2012-2016	ХХААХҮЯ, НХХЯ, БСШУЯ	ЖДҮГ, ХЭДС, АНЗДТГ, мэргэжлийн холбоод
21	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг ажлын нэгдсэн байраар хангах, тэдгээрт шаардлагатай дэд бүтцийн шинэтгэл, өргөтгөл хийх, ажлын байрны нөхцөл, нийгмийн хамгааллын асуудлыг сайжруулах, түрээсийн байрны төлбөрийн жишиг тариф тогтоох, хөнгөлөлт үзүүлэх асуудлыг судалж, санал боловсруулах	2012-2016	Холбогдох яамд	ЖДҮГ, АНЗДТГ
22	Төрийн байгууллагуудын давхардсан хяналт шалгалтыг оновчтой болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх	2012-2016	Холбогдох яамд, МХЕГ	АНЗДТГ, ТЕГ, ГЕГ
23	Байгаль орчин, хүний эрүүл мэндэд хоргүй эко-бүтээгдэхүүн үйлдвэрлэлчдийг татвар, зээлийн бодлогоор дэмжих асуудлыг судалж, санал боловсруулах	2012-2016	ХХААХҮЯ, БОАЖЯ, СЯ	АНЗДТГ, ТЕГ, ГЕГ
24	Үйлдвэрлэл эрхлэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчид бэлтгэх сургалтын тогтолцоог боловсронгуй болгох, ажиллагсдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах	2012-2016	БСШУЯ, ХХААХҮЯ, НХХЯ	Их, дээд сургууль, МБСГ, мэргэжлийн холбоод
25	Тариалангийн сүрэл, ойн хаягдлыг боловсруулж импорт орлох шахмал хавтангийн үйлдвэрийг улсын төсвийн санхүүжилтээр урт хугацаатай, хөнгөлөлттэй зэвсгэр байгуулахад дэмжлэг үзүүлэх	2012	ХХААХҮЯ, СЯ, ЭТБХЯ, ҮХШХ	ЖДҮГ, ЖДҮХС
26	Суралчийн дүрэмт хувцас, цунх, ширээ, сандлыг үндэсний үйлдвэрлэлээр бүрэн хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах, энэ зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох, төсөл хэрэгжүүлэх	2012-2013	БСШУЯ, ХХААХҮЯ, СЯ	Мэргэжлийн холбоод
27	Жижиг, дунд үйлдвэрлэл, ажлын байр болон орлого нэмэгдүүлэх чиглэлийн Засгийн газрын үндэсний хөтөлбөрүүдэд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх	2012-2013	ХХААХҮЯ, БОАЖЯ, НХХЯ	Мэргэжлийн холбоод



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 2 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 52

Улаанбаатар
хот

Байнгын төлөөлөгчийг томилох, эгүүлэн татах тухай

Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Одын Очийг Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр томилсугай.

2.Томилолтын хугацаа дууссантай холбогдуулан Очирын Энхцэцэгийг Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ГАДААД ХАРИЛЦААНЫ
САЙД**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2012 оны 05 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 15.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн орлогч дарга Н.Жанцан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат, Ж.Болдбаатар, Ж.Амарсанаа, Д.Наранчимэг, Ц.Сарантуяа, Д.Мөнхгэрэл /илтгэгч/, Б.Пүрэвням нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Н.Болортунгалагийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.



Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн П.Одгэрэл, Б.Цогтгэрэл, Н.Ариунболд, Н.Чадраабал, Ё.Бямбатогтох, Х.Сэлэнгэ нар, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Жекей, Н.Батбаяр нар оролцов.

Хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Гуравдугаар зүйлийн 1, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, Арван зургадугаар зүйлийн 9, Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянаж, эцэслэн шийдвэрлэв.

Нэг. Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны оршин суугч, иргэн Б.Цогтгэрэл Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4.9-д “Энэ хуулийн 27.1-д заасан ...28-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан улс төрийн нам буюу улс төрийн намуудын сонгуулийн эвсэл /цаашид “нам, эвсэл” гэх/-ийн жагсаалтаас тус тус сонгоно.” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар бүлгийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд...шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа өгөх зарчмыг зөрчиж байна.

Тодруулбал, Улсын Их Хурлын гишүүнийг шууд сонгох заалтыг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох хангалттай санал авч чадаагүй, өөрөөр хэлбэл шууд сонгогдоогүй нэр дэвшигчдээс бүрдэх “Г” жагсаалтын эхнээс нам, эвсэлд хуваарилагдсан суудалд дүйцүүлэн хуваарилахаар байгаа нь шууд бус замаар сонгогдож байгаа хэлбэр юм.

Түүнчлэн босго даваагүй намуудын төлөө өгсөн саналуудыг өөрчилж, өөр намууд дээр тэнцүүлэн хуваахаар байгаа нь хүний эрх, шударга ёсонд гаж, сонгогчийн эрхэд ноцтойгоор халдсан үйлдэл болжээ.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн дээрх заалтыг хүчингүй болгож өгөхийг хүсье.” гэжээ.

Хоёр. Баянгол дүүргийн 2 дугаар хорооны оршин суугч, иргэн Н.Чадраабал, Баянзүрх дүүргийн 2 дугаар хорооны оршин суугч, иргэн Ё.Бямбатогтох нар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9-д “Энэ хуулийн 27.1-д заасан нэрийн жагсаалтын эхний 48-аас



илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан сонгуулийн 26 тойргоос, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан улс төрийн нам буюу улс төрийн намуудын сонгуулийн эвсэл /цаашид “нам, эвсэл” гэх/-ийн жагсаалтаас тус тус сонгоно.” гэсэн заалт оруулснаас үүдэн уг хуульд 6.7.2, 27.5.4, 48.2, 48.7, 49.1.1, 49.1.2, 49.1.3, 49.1.7, 49.2 гэсэн зохицуулалтуудыг хийжээ. Эдгээр нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1-д “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т “Хүнийг...эрхэлсэн ажил, ... үзэл бодол, -оор нь ялгаварлан гадуурхаж үл болно...”, Арван зургадугаар зүйлийн 9-д “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...” , Арван зургадугаар зүйлийн 16-д “итгэл үнэмшилтэй байх, ... эрх чөлөөтэй...” , Хорин нэгдүгээр зүйлийн 2-т “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.”, Хорин гуравдугаар зүйлийн 1-д “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.” гэсэн заалттай тус тус зөрчилдөж байна.

Сонгуулийн тухай хуулийн 49.1.5.б-д сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан бие даан нэр дэвшигчийг хасч түүний дотор байгаа /намын нэрээр яваа/ нөхрийг сонгуульд ялсанд тооцох нь шударга өрсөлдөөний утгыг алдагдуулаад зогсохгүй ялгаварлан гадуурхсан үйл ажиллагаа юм.

Иймд энэ маргааныг хянан шийдвэрлэж Үндсэн хууль зөрчсөн заалтыг хүчингүй болгож өгөхийг хүсье.” гэжээ.

Гурав. Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны оршин суугч, иргэн П.Одгэрэл Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

“Хууль тогтоогчоос Сонгуулийн тухай хуулийг батлахдаа ямар тогтолцоог сонгох нь түүний бүрэн эрхийн асуудал боловч сонгуулийн олонхийн /мажоритар/ болон хувь тэнцүүлэх /пропорциональ/ тогтолцооны аль нэгийг үү, эсхүл аль алиных нь шинжийг агуулсан холимог тогтолцоог сонгосон уу гэдгээс үл хамааран Үндсэн хуулийн дээрх сонгуулийн суурь зарчим, үзэл санаанууд зөрчигдөх ёсгүй.

Нэг. Үндсэн хуульд заасан иргэний шууд сонгох болон сонгогдох /санал авах/ эрхийг зөрчиж буй тухайд.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4.9-д заасан “Энэ хуулийн 27.1-д заасан нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр



дэвшигчийг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан сонгуулийн 26 тойргоос, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан улс төрийн нам буюу улс төрийн намуудын сонгуулийн эвсэл /цаашид “нам, эвсэл” гэх/-ийн жагсаалтаас тус тус сонгоно.”, 27.1-д заасан “Нам, эвсэл Улсын Их Хурлын сонгуульд 76-аас илүүгүй хүнийг тухайн нам, эвслийн гаргасан дарааллын дагуу нэрийн нэг жагсаалтаар нэр дэвшүүлнэ.”, 27.5.4-т заасан “энэ хуулийн 27.1-д заасан нэрийн жагсаалтыг гаргахдаа эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчийг тойргийн дарааллаар, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 24.1, 27.4-т заасан хуралдаанаар нэр дэвшигч бүрийн авсан саналын тоо, хувиар нь эрэмбэлэн дараалалд оруулах;” гэсэн зохицуулалт нь дараах байдлаар ойлгогдож байна.

Улсын Их Хурлын сонгуульд нэг намаас нийт 76 нэр дэвшигч өрсөлдөх бөгөөд эхний 48 нь сонгуулийн мажоритар системээр 48 мандатын төлөө /26 тойрогт/ өрсөлдөнө, харин үлдсэн 28 нэр дэвшигч нь эхний буюу дээрх 48 нэр дэвшигчийн хамтаар 76-гуулаа нэрсийн нэг жагсаалтанд бичигдэж пропорциональ системээр 28 мандатын төлөө улсын хэмжээний нэг тойрогт өрсөлдөхөөр болж байна.

Гэтэл Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дээрх зүйл, заалт нь иргэдийн, сонгогчийн санал ижил тэгш үнэлэгдэх зарчмыг алдагдуулж байна. Учир нь эхний 48 нэр дэвшигчид дэмжсэн санал нь бодит байдал дээр хоёр дахин (тойрог болон намын суудал дээр) үнэлэгдэж байхад сүүлийн 28 нэр дэвшигчид сонгогчдын саналын үнэлгээ ирэхгүй байна. Энэ нь бодит байдал дээр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн холбогдох заалт Улсын Их Хурлын сонгуулийг сонгуульд оролцогч нэг нам, улс төрийн хүчний хувьд 48 хүний сонгууль болгон хувиргах төдийгүй намын жагсаалтын сүүлд бичигдсэн 28 нэр дэвшигчийн Үндсэн хуулиар олгогдсон санал авах эрхийг үгүйсгэж буйгаараа пропорциональ сонгуулийн тогтолцоон дахь шууд сонгох эрхийн агуулгыг бүрэн гажуудуулж байна.

Хоёр. Үндсэн хуулийн тэгш эрхийн зарчим болон ардчилсан ёс, шударга ёс, ард түмний төлөөллийн зарчмыг зөрчиж буй тухайд.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 49.1.6-д заасан “тойрог бүрээр гаргасан 49.1.5-д заасан “В” жагсаалтад орсон, энэ хуулийн 48.2, 48.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчдийг нам, эвсэл бүрээр нь, “В” жагсаалт дахь авсан саналын хувиар нь дараалалд оруулах ба тэдгээр нэр дэвшигчдийн дараа тойрогт нэр дэвшигчдээс бусад тухайн нам, эвслээс нэр дэвшигчдийг энэ хуулийн 27.5.4-т заасан жагсаалтад байгаа дарааллаар нь эрэмбэлж жагсаалт /цаашид “Г” жагсаалт” гэх/-ыг нам, эвсэл бүрээр нь гаргах;” гэсэн зохицуулалт нь дараах байдлаар ойлгогдож байна.

Тойрогт нэр дэвшээд сонгогчдын 28 хувиас дээш санал авсан боловч сонгогдож чадаагүй нэр дэвшигч нь /нэрийн жагсаалтын эхний

48-аас/ намын нэрийн сонголтоор дахин сонгогдох боломжийг агуулсан байна.

Нэр дэвшигч бүрийн хувьд сонгогдох буюу ялах боломж нь адил тэнцүү байх ёстой. Гэтэл дээрх зохицуулалт эхний 48 нэр дэвшигчид Улсын Их Хурлын гишүүний суудалд 2 удаа өрсөлдөх боломжийг олгосноороо үлдсэн 28 нэр дэвшигчээс давуу байдалтай болгож Үндсэн хуулийн тэгш эрхийн зарчмыг зөрчиж байна.

Сонгуулийн нэг системээр үнэлэгдсэн саналыг буюу тойрогт авсан хувь нэр дэвшигчийн саналын хувийг өөр системд шилжүүлэн үнэлж буюу намын санал авсан саналд үнэлж нэр дэвшигчийн нэрсийн жагсаалтыг хөдөлгөөнд оруулж байгаа нь тухайн системийн хувьд Үндсэн хуулийн шууд сонгох, төрийн үйл ажиллагаан дахь шударга ёсны зарчмыг зөрчихөд хүргэж, улмаар тухайн системийн бүтцийг эвдэж байна.” гэжээ.

Дөрөв. Баянгол дүүргийн 15 дугаар хорооны оршин суугч, иргэн Н.Ариунболд Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.в, 49.1.6-д тус тус зааснаас үзэхэд санал хураалт дууссаны дараа Улсын Их Хурлын мажоритар хэлбэрт ялагдал хүлээсэн нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг тусад нь жагсаан, улмаар уг жагсаалтыг сонгуулийн пропорциональ үндсэн хэлбэрээр нэр дэвшиж байгаа нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтад оруулахаар байгаа нь Үндсэн хуулийн зарим заалттай нийцэхгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, ... -ийн өмнө эрх тэгш байна.”, Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9-д “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...”, Хорин нэгдүгээр зүйлийн 2-т “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд...чөлөөтэй, ...сонгох эрхийн үндсэн дээр...сонгоно.” гэж тус тус заасан байдаг.

Гэтэл Улсын Их Хурлын сонгуулийн мажоритар хэлбэрт ялагдал хүлээсэн нэр дэвшигчдийг сонгууль дууссаны дараа Улсын Их Хурлын пропорциональ хэлбэрээр нэр дэвшиж байгаа нэр дэвшигч иргэдтэй хамт, бүр тэдгээрийн дээр нь байрлуулж, нэр дэвшигчийн шинэ жагсаалт гаргахаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн маргаан бүхий заалтад заасан байгаа нь Үндсэн хуулийн дээр дурдсан заалтуудыг зөрчсөн байна.

Маргаан бүхий заалт нь хэн нэгэн хүнд давуу байдал, зарим хүнд “дутуу” байдлыг үүсгэсэн хэм хэмжээ болжээ.



Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль ... –ийн өмнө эрх тэгш байна.”, Арван зургадугаар зүйлийн зүйлийн 1 дэх хэсгийн 9-д “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...” , Хорин нэгдүгээр зүйлийн 2-т “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд... чөлөөтэй, ... сонгох эрхийн үндсэн дээр... сонгоно.” гэж заасныг тус тус зөрчсөн эсэхийг тогтоож өгнө үү.” гэжээ.

Тав. Баянгол дүүргийн 12 дугаар хорооны оршин суугч, иргэн Х.Сэлэнгэ, Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны оршин суугч, иргэн Э.Эрдэнэжамьян, Сүхбаатар дүүргийн 3 дугаар хорооны оршин суугч, иргэн О.Баасанхүү нар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

“Ардчилсан улс орнуудад иргэдийн төрийн үйл ажиллагаанд оролцох, улс төрийн эрхийг хэрэгжүүлэхэд мажоритар, пропорциональ, холимог гэсэн 3 хэлбэрээр явуулдаг бөгөөд зарим улс орнуудын нэгэн адил холимог системийг хэрэглэх оролдлого хийж байгаа нь сайн талтай боловч процедурын алдаатай байгаа нь иргэдийн сонгох, сонгогдох эрхийг зөрчих үндэслэлийг бий болгож байна.

Ямар ч сонгуулийн системийг сонгосноос үл хамаарч Үндсэн хуулийн суурь зарчим, хүний үндсэн эрх зөрчигдөх учиргүй.

Гэтэл Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4.9, 27.1, 27.5.4, 49.1.5-р заалт нь ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдлын зарчим болон Монголын ард түмэн төрийн үйл ажиллагаанд шууд оролцож улс төрийн эрхээ эдлэх, сонгох, сонгогдох зарчим ба сонгуулийн үйл ажиллагааны үндсэн зарчим болох шууд сонгох эрхийг зөрчиж байна.

49.1.5-д энэ хуулийн 48.2-т заасан “А” жагсаалтаас дараах нэр дэвшигчдийг хасаж, хасагдсан нэр дэвшигчдийн авсан саналын хувиудын нийлбэрийг тухайн жагсаалтад үлдсэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигчдээс бусад нэр дэвшигчид тэнцүү хуваан шилжүүлэн нэмж жагсаалт гаргах гэдэг нь 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчид тэнцүү хуваан шилжүүлэн нэмж жагсаалт гаргаснаар намын нэрийн сонголтоор дахин сонгогдох боломжийг хуульчилсан байна.

Дээрх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн шууд сонгох эрхийг болон сонгуулийн үйл ажиллагаанд адил тэгш эрхтэй оролцох, ялгаварлан гадуурхуулахгүй байх эрхийг зөрчсөн байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн заалтыг хүчингүй болгож өгнө үү.” гэжээ.



Зургаа. Монгол Улсын Их Хурлын даргын 2012 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 31 дүгээр захирамжаар томилогдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Уул, Р.Гончигдорж, Ж.Сүхбаатар, Д.Одбаяр нар Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:

“Монгол Улсын Их Хурлаас 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчиж байна гэсэн Монгол Улсын иргэн П.Одгэрэл, Б.Цогтгэрэл, Н.Ариунболд, П.Сэрсмаа, Н.Чадраабал, Ё.Бямбатогтох нараас ирүүлсэн мэдээллийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэн шалгаж байгаатай холбогдуулан Улсын Их Хурлаас томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч бид дараах тайлбарыг Танд хүргүүлж байна.

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсэгт “Энэ хуулийн 27.1-д заасан нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан сонгуулийн 26 тойргоос, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан улс төрийн нам буюу улс төрийн намуудын сонгуулийн эвсэл /цаашид “нам, эвсэл” гэх/-ийн жагсаалтаас тус тус сонгоно.” гэж заасан зарчимтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.5 дахь заалт, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, 49.1.6 дахь заалтын “тойрог бүрээр гаргасан 49.1.5-д заасан “В” жагсаалтад орсон, энэ хуулийн 48.2, 48.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчдийг нам, эвсэл бүрээр нь, “В” жагсаалт дахь авсан саналын хувиар нь дараалалд оруулах ба тэдгээр нэр дэвшигчдийн дараа...” гэсэн зохицуулалтыг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд тусгасан билээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, 49.1.6 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэсэн 2 дахь хэсгийг зөрчсөн эсэх талаар:

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгээд байгаа Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтууд нь зөвхөн сонгуулийн дүнг хэрхэн гаргахтай холбогдох заалтууд болно. Сонгуулийн тойргийн хороод сонгуулийн дүнгээр тухайн тойргоос сонгогдох нэр дэвшигчийг тодруулах бөгөөд Сонгуулийн ерөнхий хороо улсын хэмжээгээр сонгуулийн дүн нэгтгэн гаргаж намуудад өгсөн саналаар сонгогдох нэр дэвшигчдийг тодруулах бөгөөд үүнтэй холбогдох



зохицуулалтууд нь дээр заасан Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэсэн заалт болно. Эдгээр заалтууд нь тойрогт нэр дэвшигчийн авсан саналын хувиар тооцон, уг нэр дэвшигчийн төлөө өгсөн сонгогчдын саналыг гээхгүйгээр сонгох, сонгогдох боломжийг олгосон зохицуулалт болно.

Өөрөөр хэлбэл, нам бүрийн 76 нэр дэвшигчийг нэгдмэл нэг жагсаалтаар сонгогчдоос авсан саналаар нь эрэмблэлтэнд оруулж, энэ эрэмбийн дагуу намын авсан суудлын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Сонгуулийн ерөнхий хорооноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцож үнэмлэх олгохтой холбогдсон зохицуулалт болно. Энэ нь сонгогчдын санал сонгуулийн дүнд илүү үр дүнтэй тусах боломжийг нээж өгсөн зохицуулалт болно. Ийнхүү нэр дэвшигчдийг эрэмблэн жагсаах нь сонгогчдын санал сонгуулийн дүнд тусаж, тэдгээрийн сонгох, сонгогдох эрх илүү хангагдаж байгаа болно.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дээрх зохицуулалт нь тойрогт нэр дэвшигчдийг тухайн тойргийн сонгогчдоос авсан саналыг нь харгалзан нам бүрээр нь нэр дэвшигчдийн нэгдсэн нэг жагсаалтад эрэмблэж оруулахдаа тойргийн сонгогчдын тоо, нэр дэвшигчдийн тоо, мандатын тооноос хамаарч болох ялгаатай байдлыг арилгасан болно.

Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасан нь төрийн үйл ажиллагаанд ямар ч нөхцөлд заавал удирдлага болгох зарчмууд билээ.

Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн дүнг эцэслэн гаргахдаа сонгогчдын саналыг гээхгүйгээр, тойргийн хүн амын тоо, тойрогт ногдсон мандат, нэр дэвшигчдийн ялгаатай байдлыг арилган суудал хуваарилан сонгох, сонгогдох эрхийг хангаж байгаа нь Ардчилсан ёс, шударга ёсыг төрийн үйл ажиллагаанд удирдлага болгосон байх зарчмыг хангаж байна гэж үзсэн болно. Ардчилсан ёсны зарчим нь төрийн засаглах эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллагыг ард түмэн өөрсдөө сонгон байгуулах, түүний үйл ажиллагаанд нь оролцох, хяналт тавих, олон ургальч үзлийг хүлээн зөвшөөрөх, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн хангах зэрэг олон хэлбэрээр илрэн хэрэгждэг. Харин сонгуулийн дүнг сонгогчдын саналыг гээхгүйгээр суудал хуваарилж байгаа нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллагыг ард түмний өөрсдийнх нь сонгох эрхийг ханган, тэдгээрийн саналыг аль болох гээхгүйгээр ард түмний хүсэл зоригийг тусгасан, ардчилсан үзэл санаанд нийцсэн томоохон шинэлэг зохицуулалт юм.

Нөгөө талаар сонгуулийн холимог тогтолцооны үндсэн шинж нь сонгуулийн мажоритар болон пропорциональ тогтолцооны дүн



гаргах аргачлалыг нэгтгэн нэг дүнг гаргахад оршино. Сонгуулийн дүнг нэгтгэхгүйгээр мажоритар болон пропорциональ тогтолцоо тус бүрээр нь гаргах нь сонгуулийн холимог тогтолцоо бус, харин паралель сонгууль болно.

Ардчилсан ёс гэдэг олонхиор бүх асуудлыг шийдвэрлэнэ гэсэн үг биш бөгөөд сонгуулийн дүнг гаргахад нам, эвслийн авсан саналаар тухайн нам, эвсэлд ногдох мандатын тоог урьдчилан гаргах бөгөөд уг дүнгээр нам, эвслээс сонгогдох нэр дэвшигчдийг сонгож байгаа нь тойргийн сонгогчдын төлөөлөл болон сонгогчдын саналыг гээлгүйгээр Үндсэн хуулийн шударга ёсны зарчмыг хангасан болно.

Сонгуулийн мажоритар тогтолцоо нь сонгогчдын санал гээдэг гэсэн томоохон шүүмжлэлийг дагуулдаг. Жишээ нь нэг тойрогт 100 мянган сонгогчтой, 2 мандат ногдож байхад тухайн тойрогт 36 мянган сонгогчийн санал авсан нэг нэр дэвшигч, 35 мянган сонгогчийн санал авсан нэг нэр дэвшигч, 34 мянган сонгогчийн санал авсан нэг нэр дэвшигч байхад уг 34 мянган сонгогчийн санал авсан нэр дэвшигч сонгогдож чадахгүй үлдэх бөгөөд уг тойргийн 34 мянган сонгогчийн санал шууд гээгдэн шударга бус байдал үүсдэг. Энэхүү шударга бус асуудлыг зохицуулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн сонгуулийн дүнг сонгогчдын саналыг гээхгүйгээр суудал хуваарилж байгаа нь төрийн үйл ажиллагаанд шударга ёсыг сахисан өөрчлөлт юм.

Шударга ёсыг хэрэгжүүлдэг үндсэн арга бол аливаад алагчлалгүй хандах бөгөөд сонгогчдын саналыг гээлгүй тэдгээрийн сонгохыг хүссэн нэр дэвшигчийн сонгогдох боломжийг хангаж байгаа нь шударга ёсыг хэрэгжүүлж байгаа хэлбэр мөн.

Төрийн үйл ажиллагааны эрх чөлөө, тэгш байдлын зарчим нь шударга ёсны зарчмаас эх үүсвэртэй бөгөөд сонгуулийн дүнгээр сонгогчдын саналыг гээхгүйгээр шилжүүлэх нь шударга ёсны зарчмыг хангаж байгаа тул төрийн үйл ажиллагаанд эрх чөлөө, тэгш байдлын зарчим зөрчигдөөгүй гэж үзэж байна.

Сонгуулийн дүнгээр холимог тогтолцооны үндсэн шинжийг агуулан суудал хуваарилж, сонгогчдын саналыг гээхгүйгээр суудал хуваарилах нь ард түмний улс төрийн, үзэл суртлын зөвшилцөөг бүрдүүлэх хэлбэрээр төрийн үйл ажиллагаанд үндэсний эв нэгдлийн үндсэн зарчмыг удирдлага болгож байгаагийн илэрхийлэл болно. Үндэсний эв нэгдэл нь тухайн орны нийт ард түмний улс төрийн, үзэл суртлын түгээмэл зөвшилцөө, эдийн засгийн тэнцвэртэй, тогтвортой хөгжил, ёс суртахуун, зан заншлын харилцан хүндэтгэл зэргээр илэрхийлэгдэн хэрэгждэг.

Сонгогчдын саналыг гээхгүйгээр сонгуулийн дүнгээр нэгтгэсэн нэг дүн гарган суудал хуваарилах нь төрийн үйл ажиллагаанд хууль дээдлэх



зарчмыг зөрчөөгүй болно. Учир нь төрийн үйл ажиллагаанд хууль дээдлэх гэдэг нь төрийн засаглах эрх мэдлийг хуваарилалт дахь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэж ангилсан гурван салаа нь тус тусдаа хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд бие даан үйл ажиллагаа явуулахыг ойлгох ба энэ нь сонгуулийн үйл ажиллагаанд хууль баримтлаж ажиллах хэлбэрээр илэрхийлэгддэг. Иймд сонгуулийн үйл ажиллагаанд хууль баримтлан суудал хуваарилах нь хууль дээдлэх зарчмыг зөрчөөгүй болно.

2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, 49.1.6 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэсэн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх талаар:

Монгол Улсын Үндсэн хуульд засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх зарчмыг хуульчилсан нь төрийн засаглах эрх мэдлийн эх сурвалж нь ард түмэн гэснийг нотолж байгаа хэлбэр бөгөөд засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна гэдэг бол ардчилал гэдэг ухагдахууны бүрэн хэмжээний илрэл юм. Ардчиллыг төлөөлөх болон шууд гэж ангилдаг бөгөөд шууд ардчиллыг хэрэгжүүлэх боломжийг хэр болохыг бүгд мэднэ. Харин төлөөлөх ардчилал гэдэг бол ард түмний сонгон байгуулсан төрийн байгууллагаараа дамжуулж төрийн засаглах эрх мэдлийг хэрэгжүүлдэг удирдлагын арга бөгөөд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалт Монгол Улсын засгийн бүх эрх мэдлийг ард түмний мэдэлд байх зарчмыг зөрчөөгүй ба ард түмэн төрийн хэрэгт шууд оролцох боломжийг нь ямар нэг байдлаар хөндөөгүй болно. Түүнчлэн сонгуулийн холимог тогтолцооны суудал хуваарилах асуудал нь сонгогчид төрийн үйл ажиллагаанд шууд оролцож, сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан эрхээ эдэлж байгааг зөрчөөгүй болно. Учир нь ард түмний хүсэл зоригийг зөвхөн олонхийн саналаар шийдвэрлэх хэт хатуу тогтолцоог эвдэн шударга ёсыг сахин, ард түмний зарим хэсгийн хүсэл зоригийг гээлгүй, орхигдуулалгүй асуудлыг зөв талаас нь тайлбарлан танилцуулан шийдвэрлэсэн болно.

3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, 49.1.6 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэсэн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх талаар:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4.9 дахь заалт, түүнтэй холбогдох заалт нь сонгууль зохион байгуулан нэр дэвшигчдэд сонгуулийн дүн гарган тооцож, суудал хуваарилах асуудлыг зохицуулж



байгаа бөгөөд уг асуудал нь хэн нэг нэр дэвшигчийн хуулийн өмнө эрх тэгш байдлыг алдагдуулсан зүйл байхгүй юм. Учир нь нэр дэвшигч бүр хуулийн өмнө эрх тэгш байх бөгөөд хуульд заасны дагуу нам, эвслийн авсан саналын хувиар ногдсон мандатыг хуваарилах нь тухайн тойргийн сонгогчдын саналыг тэгш хадгалагдах боломжийг нээж өгсөн болно. Өөрөөр хэлбэл, сонгогчдын санал гээгдэх нь хуулийн өмнөх эрх тэгш байдлыг алдагдуулж байсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд сонгуулийн хоёр тогтолцооны дүнг нэгтгэн суудал хуваарилах асуудлыг зохицуулсан нь илүү оновчтой Үндсэн хуульд нийцсэн зохицуулалт болсон гэж үзэж байна.

4. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, 49.1.6 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн "...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй." гэсэн 9 дэх хэсгийг зөрчсөн эсэх талаар:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, 49.1.6 дахь заалтууд нь Монгол Улсын иргэний төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхийг зөрчөөгүй гэж үзэж байна. Учир нь Улсын Их Хуралд улс төрийн нам, эвслээс 76-аас илүүгүй хүний нэрийг дэвшүүлэх эрхтэй бөгөөд уг 76 нэр дэвшигчийн 48-аас илүүгүй нь тойрогт нэр дэвших ба Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд пропорциональ тогтолцоогоор 28-аас илүүгүй нэр дэвшигчид суудал хуваарилахдаа тухайн нам, эвслийн авсан саналын хувиар нь нэр дэвшигчдийн төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй нь хамааралгүйгээр тооцон гаргах бөгөөд энэхүү суудал хуваарилан нэр дэвшигчдийн төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхийг нь зөрчөөгүй болно. Мөн төрийн удирдах хэрэгт иргэдийн оролцох нь тэдгээрийн улс төрийн үндсэн эрх бөгөөд иргэд төрийн удирдах хэрэгт шууд шийдвэрлэх эрхтэй буюу эсхүл өөрсдийн сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан энэ эрхээ эдэлдэг. Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэн хянах ажиллагаа явагдаж байгаа холбогдох заалт нь иргэний сонгох, сонгогдох эрхэд халдсан зүйл байхгүй юм. Нэр дэвшигчийн сонгох, сонгогдох эрх нь хязгаарлагдаагүй бөгөөд тэдгээрийн сонгогдох нь тухайн тойргийн сонгогчдын нэр дэвшигчид үзүүлж байгаа үнэлгээ, түүнчлэн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт олон түмнээс өгсөн үнэлгээтэй холбогдон гаргасан саналтай нь шууд хамааралтай тул уг асуудлыг шууд Үндсэн хуулийн иргэний төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхийг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй.

5. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, 49.1.6 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн



“Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, ...сонгоно.” гэсэн 2 дахь хэсгийг зөрчсөн эсэх талаар:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, 49.1.6 дахь заалт нь Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй сонгоход ямар нэг хязгаарлалт агуулаагүй тул Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн уг заалтууд нь Үндсэн хуулийн Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй сонгох зарчмыг зөрчөөгүй болно. Түүнчлэн дээрх маргаантай заалтууд нь сонгогчийн саналаа нууцаар гаргахад нь хамааралгүй билээ.

Уг заалтыг сонгогчийн шууд сонгох эрхийг зөрчиж байна гэж үзэх нь эрх зүйн хувьд үндэслэлгүй юм. Шууд сонгох гэдэг нь нэгд: сонгогч сонгуульд ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож саналаа өөрөө гаргах, хоёрт: сонгогчдын саналын үндсэн дээр сонгуулийн дүнг хуулиар тогтоосон журмын дагуу шууд гардаг гэсэн агуулгатай тул Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалт нь Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Улсын Их Хурлын гишүүнийг...шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, ...сонгоно.” гэснийг зөрчөөгүй төдийгүй, сонгуулийн дүн нь шууд гарч байх хуулийн журмыг тогтоож байгаа юм.

Ийнхүү үндэслэлүүдээр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, 49.1.6 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн, Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн, Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсгийн, Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчөөгүй болно.” гэжээ.

Долоо. Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 3 дугаар сарын 28-ний өдрийн дунд суудлын хуралдаанаар энэхүү маргааныг хэлэлцэж 02 дугаар дүгнэлт гаргасан байна. Уг дүгнэлтийн үндэслэл хэсэгт:

“1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох хэсгийн зохицуулалт нь Улсын Их Хурлын сонгуулийн 26 тойрогт 48 мандатын төлөө нэр дэвшигчдээс тус тусын тойрогтоо ялагдах хүлээсэн боловч тэдгээрээс 28 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох боломжийг бий болгон хуульчилснаараа зарим нэр дэвшигч нарт давуу байдал бий болгон Үндсэн хуульд заасан хуулийн өмнө эрх тэгш байх зарчмын агуулгыг алдагдуулсан байна.



2.Түүнчлэн сонгуулийн эрх бүхий иргэд нэгэнт сонголтоо хийсэн байтал дээрх зохицуулалт нь Улсын Их Хурлын 26 тойрогт нэр дэвшээд тус тусын тойрогт ялагдал хүлээсэн боловч 28 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигч улс төрийн нам, эвслийн жагсаалтад шилжин орсноор Улсын Их Хурлын гишүүний мандат буюу суудлыг нам, эвсэлд тэдгээрийн авсан саналын хувь хэмжээгээр хуваарилах агуулгатай сонгуулийн хувь тэнцүүлэх хэлбэр хэрэгжих боломжгүйд хүрч, улмаар иргэдийн шууд сонгох эрхийг алдагдуулсан байна.

3.Мөн Улсын Их Хуралд нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчид өгсөн санал хоёр удаа буюу сонгуулийн олонхийн болон хувь тэнцүүлэх хэлбэрт тус тус үнэлэгдсэнээр, намын нэрээр өгсөн сонгогчдын санал эзэнгүйдэн, улс төрийн нам, намуудын сонгуулийн эвслийн жагсаалтад орсон 28 нэр дэвшигчид өгсөн саналыг бодитойгоор үнэлэх боломжгүй байдалд хүргэн, тэдгээрийн сонгогдох эрхийг хязгаарласан байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох хэсгийн зохицуулалт нь дээр дурдсан зөрчлийн шинжийг агуулснаараа ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдал, засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байх Үндсэн хуулийн суурь зарчимд харшилсан байна.” гэжээ.

Тогтоох хэсэгт:

“1.Улсын Их Хурлын сонгуулийн 26 тойрогт 48 мандатын төлөө нэр дэвшигчдээс тус тусын тойрогтоо ялагдал хүлээсэн боловч тэдгээрээс 28 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох боломжийг бий болгон хуульчилсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсэгт “... энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан...”, 49 дүгээр зүйлийн 49.1.5 дахь заалтад “энэ хуулийн 48.2-т заасан “А” жагсаалтаас дараах нэр дэвшигчдийг хасаж, хасагдсан нэр дэвшигчдийн авсан саналын хувиудын нийлбэрийг тухайн жагсаалтад үлдсэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигчдээс бусад нэр дэвшигчид тэнцүү хуваан шилжүүлэн нэмж жагсаалт /цаашид “В” жагсаалт” гэх/-ыг гаргах.”, 49.1.5.а заалтад “санал өгсөн сонгогчдын 28-аас доош хувийн санал авсан нэр дэвшигч;”, 49.1.5.б заалтад “санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бие даан нэр дэвшигч;”, 49.1.5.в заалтад “санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бөгөөд улсын хэмжээнд таваас доош хувийн санал авсан нам, эвслээс нэр дэвшигч.”, 49.1.6 дахь заалтад “тойрог бүрээр



гаргасан 49.1.5-д заасан “В” жагсаалтад орсон, энэ хуулийн 48.2, 48.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчдийг нам, эвсэл бүрээр нь, “В” жагсаалт дахь авсан саналын хувиар нь дараалалд оруулах ба тэдгээр нэр дэвшигчдийн дараа...” гэж заасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...”, Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж... сонгоно.” гэснийг тус тус зөрчсөн байна.

2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсгийн “... энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан...”, 49 дүгээр зүйлийн 49.1.5 дахь заалтын “энэ хуулийн 48.2-т заасан “А” жагсаалтаас дараах нэр дэвшигчдийг хасаж, хасагдсан нэр дэвшигчдийн авсан саналын хувиудын нийлбэрийг тухайн жагсаалтад үлдсэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигчдээс бусад нэр дэвшигчид тэнцүү хуваан шилжүүлэн нэмж жагсаалт /цаашид “В” жагсаалт” гэх/-ыг гаргах.”, 49.1.5.а заалтын “санал өгсөн сонгогчдын 28-аас доош хувийн санал авсан нэр дэвшигч;”, 49.1.5.б заалтын “санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бие даан нэр дэвшигч;”, 49.1.5.в заалтын “санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бөгөөд улсын хэмжээнд таваас доош хувийн санал авсан нам, эвслээс нэр дэвшигч.”, 49.1.6 дахь заалтын “тойрог бүрээр гаргасан 49.1.5-д заасан “В” жагсаалтад орсон, энэ хуулийн 48.2, 48.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчдийг нам, эвсэл бүрээр нь, “В” жагсаалт дахь авсан саналын хувиар нь дараалалд оруулах ба тэдгээр нэр дэвшигчдийн дараа...” гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2012 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.” гэжээ.



Найм. Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал 2012 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцээд хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн 26 дугаар тогтоол гаргасан байна. Уг тогтоолд:

“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсэгт “...энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан...”, 49 дүгээр зүйлийн 49.1.5 дахь заалтад “энэ хуулийн 48.2-т заасан “А” жагсаалтаас дараах нэр дэвшигчдийг хасаж, хасагдсан нэр дэвшигчдийн авсан саналын хувиудын нийлбэрийг тухайн жагсаалтад үлдсэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигчдээс бусад нэр дэвшигчид тэнцүү хуваан шилжүүлэн нэмж жагсаалт /цаашид “В” жагсаалт” гэх/-ыг гаргах.”, 49.1.5.а заалтад “санал өгсөн сонгогчдын 28-аас доош хувийн санал авсан нэр дэвшигч;”, 49.1.5.б заалтад “санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бие даан нэр дэвшигч;”, 49.1.5.в заалтад “санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бөгөөд улсын хэмжээнд таваас доош хувийн санал авсан нам, эвслээс нэр дэвшигч.”, 49.1.6 дахь заалтад “тойрог бүрээр гаргасан 49.1.5-д заасан “В” жагсаалтад орсон, энэ хуулийн 48.2, 48.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчдийг нам, эвсэл бүрээр нь, “В” жагсаалт дахь авсан саналын хувиар нь дараалалд оруулах ба тэдгээр нэр дэвшигчдийн дараа...” гэж заасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...” , Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийгээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж... сонгоно.” гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.” гэжээ.



Ес. Монгол Улсын Их Хурлын даргын 2012 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 60 дугаар захирамжаар Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Х.Жекей, Н.Батбаяр нар Үндсэн хуулийн цэцэд тайлбараа ирүүлсэн байна. Уг тайлбартаа:

“Монгол Улсын Их Хурлаас 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчиж байна гэсэн Монгол Улсын иргэн П.Одгэрэл, Б.Цогтгэрэл, Н.Ариунболд, Н.Чадраабал, Ё.Бямбатогтох, Э.Эрдэнэжамъян, Х.Сэлэнгэ, О.Баасанхүү нарын нэр бүхий иргэдээс ирүүлсэн мэдээллийг Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэн хянан шалгаж, 2012 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн дунд суудлын хуралдаанаараа хэлэлцэн 02 дугаар дүгнэлт гаргасан билээ.

Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал 2012 оны 4 дүгээр сарын 12, 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэн Улсын Их Хурлын 2012 оны 26 дугаар тогтоолыг баталсан.

Улсын Их Хурлаас томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгчид Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Үүл, Р.Гончигдорж, Д.Одбаяр, Ж.Сүхбаатар нарын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд хүргүүлсэн тайлбарыг дэмжиж байгаагаа илэрхийлэн Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд оролцохоор Улсын Их Хурлаас томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч бид дараах тайлбарыг хүргүүлж байна:

1. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны дээрх дүгнэлт Үндсэн хуулийн тулгуур зарчим болсон Улсын Их Хурал нь төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдэл зөвхөн Улсын Их Хуралд хадгалагдана гэсэн зарчимтай зөрчилдөж байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх заалтын холбогдох зохицуулалт, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох зохицуулалт нь Үндсэн хуулийн маргааны асуудал биш юм. Нөгөө талаар Үндсэн хуулийн цэц хэрэв асуудлыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг өөрчилвөл хууль тогтоох эрх мэдэл зөвхөн Монгол Улсын Их Хуралд хадгалагддаг байх Үндсэн хуулийн дээд зарчмыг зөрчсөн үйл явдал болно гэж үзэж байна.

Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх заалтын холбогдох зохицуулалт, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в,



мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох зохицуулалтыг хүчингүй болгож байгаа нь “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно” гэсэн Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дугаар заалттай илт зөрчилдөж байна. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээс харахад Улсын Их Хуралд орж ирж байгаа 76 хүний 48 нь ард түмний санал авч мандат авсан гишүүд байх бөгөөд 28 нь намаасаа мандат авсан гишүүд сонгогдохоор байна. Намын нэрээр сонгогдсон Их Хурлын гишүүд, ард түмнээс сонгогдсон Их Хурлын гишүүд гэсэн хоёр статустай гишүүдтэй болж байна.

2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх заалтын холбогдох зохицуулалт, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох зохицуулалт нь Үндсэн хуулийн заалтуудыг зөрчжээ гэдэг зөрчил нь Үндсэн хуулийн зөрчил биш юм. Харин Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн эдгээр заалт нь ардчилсан ёс, шударга ёс, эрх тэгш, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах зарчмыг хангасан зохицуулалт юм.

3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д “Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх зургаан сарын дотор Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах буюу түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.” гэж заасан байгаа. Энэ заалт нь Улсын Их Хурал хууль тогтоогчид хамааралтай болохыг Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд тайлбарласан байна.

Гэтэл Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах;” гэж заасан заалтыг Үндсэн хуулийн цэц зөрчиж байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын дээд шүүх Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар тайлбар гаргах бүрэн эрхтэй байхад Үндсэн хуулийн цэц Улсын дээд шүүхийн бүрэн эрхэд халдаж Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх заалтыг зөвхөн Улсын Их Хуралд хамааралтай болохыг тайлбарласан байна. Энэ талаар Улсын дээд шүүх тайлбар гаргаагүй байгаа болно.

4.Үндсэн хуулийн Жаран есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнө зургаан сарын дотор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болно” гэсэн хориглолт байдаг. Үүнийг дагасан заалт нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд орсон.

Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнө зургаан сарын дотор Үндсэн хууль болон Монгол Улсын Их Хурлын



сонгуулийн тухай хуульд аливаа нэг субъект нэмэлт, өөрчлөлт оруулах эрхгүй. Монгол Улсын Их Хурлаас 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль нь Монгол Улсад өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа тул Үндсэн хуулийн хууль дээдлэх зарчмыг төрийн бүх байгууллага нэг мөр ойлгон гуйвуулалтгүй хэрэгжүүлэх үүрэгтэй.

Ийнхүү үндэслэлүүдээр Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй бөгөөд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, 49.1.6 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн, Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн, Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсгийн, Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчөөгүй байна гэж Улсын Их Хурал үзсэнийг уламжилж байна.” гэжээ.

Арав. Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааны явцад мэдээлэл гаргагч, иргэн Н.Ариунболд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан эрхийн хүрээнд мэдээллийнхээ шаардлагаас бүхэлд нь татгалзсан болно.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох хэсгийн зохицуулалт нь Улсын Их Хурлын сонгуулийн 26 тойрогт 48 мандатын төлөө нэр дэвшигчдээс тус тусын тойрогтоо ялагдал хүлээсэн боловч тэдгээрээс 28 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох боломжийг олгож байгаагаараа зарим нэр дэвшигч нарт давуу байдал бий болгон Үндсэн хуульд заасан хуулийн өмнө эрх тэгш байх болон сонгуулийн шууд сонгох зарчмын агуулгыг алдагдуулсан байна.

2. Мөн Улсын Их Хуралд нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчид өгсөн санал хоёр удаа буюу сонгуулийн олонхийн болон хувь тэнцүүлэх хэлбэрт тус тус үнэлэгдсэнээр, намын нэрээр өгсөн сонгогчдын санал эзэнгүйдэн улс төрийн нам, намуудын сонгуулийн эвслийн жагсаалтад орсон 28 нэр дэвшигчид өгсөн саналыг бодитойгоор үнэлэх боломжгүй байдалд хүргэн иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хязгаарласан байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох хэсгийн зохицуулалт нь дээр



дурдсан зөрчлийн шинжийг агуулснаараа ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдал, засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байх Үндсэн хуулийн суурь зарчимд харшилсан байна.

3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Гуравдугаар зүйлийн 1, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, Арван зургадугаар зүйлийн 9, Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчсөн гэж үзсэн Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсэгт "... энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан...", 49 дүгээр зүйлийн 49.1.5 дахь заалтад "энэ хуулийн 48.2-т заасан "А" жагсаалтаас дараа нэр дэвшигчдийг хасаж, хасагдсан нэр дэвшигчдийн авсан саналын хувиудын нийлбэрийг тухайн жагсаалтад үлдсэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигчдээс бусад нэр дэвшигчид тэнцүү хуваан шилжүүлэн нэмж жагсаалт /цаашид "В" жагсаалт" гэх/-ыг гаргах.", 49.1.5.а заалтад "санал өгсөн сонгогчдын 28-аас доош хувийн санал авсан нэр дэвшигч;", 49.1.5.б заалтад "санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бие даан нэр дэвшигч;", 49.1.5.в заалтад "санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бөгөөд улсын хэмжээнд таваас доош хувийн санал авсан нам, эвслээс нэр дэвшигч.", 49.1.6 дахь заалтад "тойрог бүрээр гаргасан 49.1.5-д заасан "В" жагсаалтад орсон, энэ хуулийн 48.2, 48.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчдийг нам, эвсэл бүрээр нь, "В" жагсаалт дахь авсан саналын хувиар нь дараалалд оруулах ба тэдгээр нэр дэвшигчдийн дараа..." гэж заасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард



түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...”, Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж... сонгоно.” гэснийг тус тус зөрчсөн байх тул Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дээрх заалтуудыг хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.5.в заалтад хамаарах “Тайлбар: Энэ хуулийн 48.5-д заасны дагуу дахин санал хураалтад орсон боловч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчийн “В” жагсаалт дахь өөрийн авсан саналын хувь нь анхны санал хураалтын саналын хувь байна.” гэснийг хүчингүй болгосугай.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын 2012 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 26 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

4. Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааны энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

ГИШҮҮД

Н.ЖАНЦАН

**П.ОЧИРБАТ
Ж.БОЛДБААТАР
Ж.АМАРСАНАА
Д.НАРАНЧИМЭГ
Ц.САРАНТУЯА
Д.МӨНХГЭРЭЛ
Б.ПҮРЭВНЯМ**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: tugiin_medecelel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас: 4

Индекс: 14003